



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 20 (353)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Даатгалын тухай (шинэчилсэн найруулга)*
- *Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны тавдугаар сарын 24 №20 (353)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

248.	Даатгалын тухай (Шинэчилсэн найруулга)	443
249.	Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай	464
250.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	477
251.	Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай	477
252.	Хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	477

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

253.	Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг батлах тухай	Дугаар 21	477
254.	Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай	Дугаар 22	486
255.	Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах тухай	Дугаар 23	486

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ДААТГАЛЫН ТУХАЙ

(Шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Даатгалын тухай хууль

ТОГТООМЖ

2.1. Даатгалын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², Компанийн тухай хууль³, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Нийгмийн даатгалын болон иргэний эрүүл мэндийн даатгалын харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

3.2. Даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх гэрээний харилцааг Иргэний хуулиар зохицуулна.

¹ Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны №1

² Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны № 7

³ Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны № 34

3.3. Даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийн эрх зүйн байдлыг Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиар зохицуулна.

3.4. Даатгалын үйл ажиллагаатай холбогдсон энэ хуулийн 3.1-3.3-т зааснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

4.1.1. "даатгалын үйл ажиллагаа" гэж даатгалын гэрээний дагуу даатгагч нь даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажиллагааг;

4.1.2. "даатгагч" гэж энэ хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанийг;

4.1.3. "даатгуулагч" гэж өөрийн ашиг сонирхлын төлөө даатгалын зүйлээ даатгуулж, даатгагчтай гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийг;

4.1.4. "даатгалын тохиолдол" гэж даатгуулсан зүйлд учирсан хохирол, тохиролцсон бэлзэл бүрдэхийг;

4.1.5. "даатгалын хураамж" гэж даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг;

4.1.6. "даатгалын нөхөн төлбөр" гэж гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгийг;

4.1.7. "даатгалын багц дүрэм" гэж энэ хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах зорилгоор гаргаж буй дүрэм, журам, заавар, нөхцөл, шаардлагыг;

4.1.8. "актуарч" гэж даатгагчийн төлбөрийн чадварын түвшин, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор учирч болзошгүй эрсдлийг урьдчилан үнэлж, эдийн засаг, математикийн тооцоо, судалгааны үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг этгээдийг;

4.1.9. "давхар даатгалын үйл ажиллагаа" гэж даатгагч нь даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дахин даатгахыг;

4.1.10. "гадаадын зохицуулах байгууллага" гэж даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий гадаад улсын байгууллагыг;

4.1.11. "эрх бүхий албан тушаалтан" гэж

Компанийн тухай хуулийн 81.1-д заасан этгээдийг.

4.2. Давхар даатгалын үйл ажиллагаанд энэ хуулийн 4.1.1-дэх заалт нэгэн адил хамаарна.

4.3. Бодит хохирлоос үл хамааран тодорхой итгэлцүүр буюу бусад аргачлалыг ашиглан даатгагчийн хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг томъёогоор дундажлан тооцоолж гаргадаг үйл ажиллагаа энэ хуулийн 4.1.1-д нэгэн адил хамаарна.

5 дугаар зүйл. Гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүний даатгал

5.1. Гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгө, эдийн бус хөрөнгөө Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн нэгэн адил нөхцөлөөр даатгуулах эрхтэй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Даатгалын ангилал, төрөл, хэлбэр

6 дугаар зүйл. Даатгалын ангилал, төрөл, хэлбэр

6.1. Даатгалыг урт хугацааны даатгал, ердийн даатгал гэж ангилна.

6.2. Даатгал нь сайн дурын болон заавал гэсэн төрөлтэй байна.

6.3. Даатгалын төрөл тус бүр нь хэлбэртэй байх бөгөөд заавал даатгах даатгалын хэлбэрийг хуулиар тогтооно.

6.4. Заавал даатгуулах даатгалын эрсдэл, нөхцөлийн талаархи нарийвчилсан зохицуулалтыг уг даатгалыг заавал даатгуулах даатгал гэж тодорхойлсон хуулиар зохицуулна.

6.5. Сайн дурын даатгалын хэлбэрийг Санхүүгийн зохицуулах хороо тогтооно.

6.6. Даатгагчийн үйл ажиллагаа нь энэ хуулийн дагуу тодорхойлсон ангилал, төрөл, хэлбэрээс өөр байна гэж үзвэл энэ хуульд нийцүүлэхийг Санхүүгийн зохицуулах хороо даатгагчид даалгаж болно.

7 дугаар зүйл. Даатгалын хураамж

7.1. Заавал даатгалын хураамжийн хэмжээг Монгол Улсын хуулиар тогтооно.

7.2. Сайн дурын даатгалын хураамжийн хэмжээг энэ хуулийн 14.2.5-д заасан аргачлалын дагуу даатгагч тогтооно.

8 дугаар зүйл. Даатгалын нөхөн төлбөр

8.1. Даатгагч нь хууль болон гэрээнд заасан нөхцөлийн дагуу энэ хуулийн 8.4-т заасан баримтыг

үндэслэн даатгуулагчид даатгалын нөхөн төлбөрийг олгоно.

8.2 Даатгалын гэрээнд заасан тохиолдолд нөхөн төлбөрийг даатгуулагчийн буруугаас хохирсон гуравдагч этгээдэд шууд олгож болно.

8.3 Даатгуулагч нас барсны дараа даатгалын тохиолдол үүссэн бол даатгалын нөхөн төлбөрийг түүний хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид олгоно.

8.4 Даатгалын нөхөн төлбөрийг дараахь баримтыг үндэслэн олгоно:

8.4.1 даатгуулагчийн өргөдөл;

8.4.2 даатгалын баталгааны эх хувь;

8.4.3 учирсан хохирлын тухай хохирол үнэлэгчийн бичгээр гаргасан дүгнэлт, акт материал;

8.4.4 шаардлагатай гэж үзвэл холбогдох мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, тодорхойлолт.

8.5 Даатгагч дараахь үндэслэлээр нөхөн төлбөрийг бүрэн буюу түүний зарим хэсгийг олгохоос татгалзаж болно.

8.5.1 даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол бий болох нөхцөл, орчныг бүрдүүлсэн;

8.5.2 даатгуулагч даатгалын зүйлийн талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

8.5.3 даатгалын гэрээнд зааснаас бусад шалтгаанаар хохирол гарсан;

8.5.4 гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн;

8.5.5 хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

8.6 Даатгагч нь нөхөн төлбөр олгохоос татгалзсан үндэслэлээ тодорхой гаргаж, даатгуулагчид бичгээр мэдэгдэнэ.

8.7 Даатгалын гэрээнд заасан бол буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх даатгуулагчийн эрх нь даатгалаар олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр даатгагчид шилжинэ.

9 дүгээр зүйл. Даатгагчийн эрх, үүрэг

9.1 Даатгагч дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

9.1.1 энэ хуулийн 8.5-д заасан үндэслэлийн дагуу даатгалын нөхөн төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн олгохоос татгалзах;

9.1.2 даатгуулагчийн эрх, үүрэг нь шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд даатгагч гэрээнд өөрчлөлт оруулах саналыг шинэ эзэмшигчид тавих;

9.1.3 даатгуулагч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, эсхүл түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;

9.1.4 даатгалын тохиолдол болсон үед нөхөн төлбөрийг хууль болон гэрээгээр тохиролцсон хугацаа, хэмжээнд олгох;

9.1.5 даатгалын баталгааг гэрээнд заасан хугацаанд даатгуулагчид олгох;

9.1.6 даатгалын хууль тогтоомж, гэрээний нөхцөлийг даатгуулагчид танилцуулах;

9.1.7 Монгол Улсын хуулиар зөвшөөрснөөс бусад нөхцөлд даатгуулагчийн талаархи мэдээ, материалын нууцыг задруулахгүй байх;

9.1.8 даатгалын эрсдэлийн улмаас учирч болох хохирлын хэмжээг багасгах зорилгоор даатгуулагчийн авсан арга хэмжээний өртгийг даатгуулагчид нөхөн төлөх;

9.1.9 даатгуулагч нас барсан тохиолдолд түүний эрх, үүргийг хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид нь шилжүүлэх;

9.1.10 гэрээний хугацаанд даатгуулагч эрх зүйн чадамжгүй нь тогтоогдвол түүний эрх, үүргийг хэрэгжүүлэхийн тулд хууль ёсны асран хамгаалагчийг шүүхээр тогтоолгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

9.1.11 Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу санхүүгийн тайлангийн хураангуйг хэвлэлд нийтлэх.

10 дугаар зүйл. Даатгуулагчийн эрх, үүрэг

10.1 Даатгуулагч дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

10.1.1 даатгалын тохиолдол болсон үед гэрээний нөхцөлийн дагуу нөхөн төлбөр олгохыг даатгагчаас шаардах;

10.1.2 даатгагч хууль болон гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, эсхүл түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;

10.1.3 даатгуулагчийн эрх, үүрэг шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд шинэ эзэмшигч гэрээнд өөрчлөлт оруулах саналыг даатгагчид тавих;

10.1.4 даатгалын хураамжийг хууль болон гэрээнд заасан хугацаанд даатгагчид төлөх;

10.1.5. даатгалын зүйлийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тохиолдол болсон үед хохирлыг багасгах зорилгоор бололцоотой арга хэмжээг авах, даатгагчид нэн даруй мэдэгдэх;

10.1.6. даатгал хийлгэхтэй холбогдсон баримт материалыг даатгагчид үнэн зөв гаргаж өгөх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Даатгалын үйл ажиллагааг төрөөс зохицуулах

11 дүгээр зүйл. Даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

11.1. Даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь даатгалын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1. даатгалын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;

11.1.2. Засгийн газрыг даатгалын бодлогын зөвлөгөөгөөр хангах;

11.1.3. хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

12 дугаар зүйл. Даатгалын зохицуулах байгууллага

12.1. Даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хянах эрхийг даатгалын асуудал хариуцсан Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Зохицуулах хороо" гэх/ хэрэгжүүлнэ.

12.2. Зохицуулах хорооны үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын бүтцийг Улсын Их Хурал баталж, улсын төсвөөс санхүүжүүлнэ.

12.3. Зохицуулах хороо Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнана.

13 дугаар зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх

13.1. Зохицуулах хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1. энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгагчийн даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих;

13.1.2. даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

13.1.3. даатгалын багц дүрмийг

батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих;

13.1.4. даатгалын дотоод, гадаад зах зээлийг судлах, даатгалын талаархи албан ёсны мэдээлэл гаргах;

13.1.5. даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн нэгдсэн бүртгэл хөтөлөх;

13.1.6. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

13.2. Зохицуулах хороо нь даатгагч дамлуурах болон даатгалын үйл ажиллагаатай холбоотой хууль бус үйл ажиллагаанаас үүсч болзошгүй хохирлоос даатгуулагч болон олон нийтийг хамгаалах зорилгоор байнгын хяналтыг хэрэгжүүлнэ.

14 дүгээр зүйл. Даатгалын багц дүрэм

14.1. Даатгалын үйл ажиллагааг Зохицуулах хорооноос баталсан даатгалын багц дүрмээр зохицуулна.

14.2. Даатгалын багц дүрэмд дараахь дүрэм, журам, заавар, нөхцөл, шаардлага, хэмжээ багтана:

14.2.1. даатгагчид тавигдах шаардлага, даатгагчийн дагаж мөрдөх үзүүлэлт;

14.2.2. даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам;

14.2.3. даатгалын нөөц сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам;

14.2.4. даатгалын нөөц санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага;

14.2.5. даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлал;

14.2.6. даатгалын үнэлгээ хийх аргачлал;

14.2.7. даатгагч болон бусад этгээдээс даатгалын мэргэжлийн оролцогчид шууд болон шууд бусаар төлөх төлбөр, хураамжийг тооцох аргачлал;

14.2.8. даатгагчийн аудиторт тавигдах нөхцөл, шаардлага;

14.2.9. актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох болон актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам;

14.2.10. гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа явуулах даатгагчид тавигдах нөхцөл, шаардлага;

14.2.11. Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа явуулах гадаадын даатгагчид тавигдах нөхцөл, шаардлага;

14.2.12. даатгагчаас даатуулагчид төлбөртэйгээр мэдээлэл, баримт бичиг өгөх нөхцөл, төлбөрийн жишиг хэмжээ;

14.2.13. даатгагчаас энэ хуульд заасны дагуу тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар;

14.2.14. даатгагчаас үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг бусдад шилжүүлэх болон нэгтгэх үед гаргах өргөдлийг хянан шийдвэрлэх журам;

14.2.15. энэ хуульд заасан тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт;

14.2.16. даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага;

14.2.17. Зохицуулах хороонд төлөх төлбөр, хураамж;

14.2.18. Дампуурлын тухай хууль¹, Компанийн тухай хуулиас гадуур даатгагчийг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг явуулах журам;

14.2.19. даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоох нөхцөл;

14.2.20. даатгалтай холбоотой үйл ажиллагааг тодорхойлох заавар;

14.2.21. энэ хуульд заасан мэдээллийг хэвлэн нийтлэх журам.

15 дугаар зүйл. Даатгагчийн бизнесийн үйл ажиллагаа явуулах журам

15.1. Зохицуулах хорооноос даатгагчийн үйл ажиллагааг зохиистой явуулах зорилгоор тусгайлан журам гаргаж болно.

15.2. Даатгагч энэ хуулийн 15.1-д заасан журмыг заавал дагаж мөрдөх үүргийг хүлээхгүй боловч ийнхүү дагаж мөрдөөгүй нь даатгагчид хариуцлага ногдуулахад түүнийг даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмших тохиромжтой бус этгээд, эсхүл үйл ажиллагаагаа зохиистой явуулаагүй гэж үзэх нөхцөл болж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох

¹Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны №11

²Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны №6

16 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглох

16.1. Энэ хуулийн 16.3, 17.2-т зааснаас бусад этгээд Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад болон Монгол Улсаас гадаад улсын нутаг дэвсгэрт даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

16.2. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд гадаад улсын нутаг дэвсгэрт даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа бол энэ хуулийн 16.1-д заасны дагуу Монгол Улсаас гадаад улсын нутаг дэвсгэрт даатгалын үйл ажиллагаа явуулсанд тооцно.

16.3. Даатгагчтай гэрээ байгуулан давхар даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаад улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдэд энэ хуулийн 16.1 дэх хэсэг хамаарахгүй.

16.4. Энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон даатгагч энэ хуулийн 16.1-д заасанчлан даатгалын үйл ажиллагаа явуулах эрхгүй.

16.5. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар² зохицуулна.

17 дугаар зүйл. Даатгагчийн даатгах хөрөнгө

17.1. Монгол Улсад оршин суугч хувь хүн, хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт буй эд хөрөнгөө гагцхүү энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгагчид даатгуулна.

17.2. Энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл аваагүй гадаадын даатгагч тухайлбал, Ллойдын андеррайтерын холбоонд багтдаг даатгагчтай даатгалын гэрээ байгуулж болох бөгөөд гэрээ байгуулах тохиолдолд бүрт Зохицуулах хорооноос зөвшөөрөл авна.

17.3. Энэ хуулийн 17.2-т заасан гэрээ байгуулах зөвшөөрлийг Зохицуулах хороо зөвхөн дараахь тохиолдолд олгоно:

17.3.1. энэ хуулийн 17.1-д заасан даатгагч тухайн даатгалын эрсдэлийг хариуцах чадваргүй;

17.3.2. энэ хуулийн 17.1-д заасан даатгагч эрсдлийг хариуцах боломжгүй гэж үзэх бусад хүндэтгэх шалтгаан байвал.

17.4. Гадаадын даатгагчтай давхар даатгалын гэрээ байгуулах даатгагчид дараахь тохиолдолд энэ хуулийн 17.3 дэх хэсэг хамаарахгүй:



17.4.1.энэ хуулийн 47.1-д заасны дагуу давхар даатгалын төлөвлөгөөг Зохицуулах хороогоор батлуулсан бол;

17.4.2.энэ хуулийн 47.2-т заасны дагуу тухайн гэрээнд давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага хамаарахгүй байхаар Зохицуулах хорооноос тогтоосон бол.

18 дугаар зүйл. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах эрх бүхий этгээд

18.1.Дараахь этгээд даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргах эрхтэй:

18.1.1.Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компани;

18.1.2.гадаад улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан компани.

19 дүгээр зүйл. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэх тухай өргөдөл гаргах

19.1.Энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан этгээд нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлөө Зохицуулах хороонд гаргана.

19.2.Өргөдлийг бичгээр гаргах бөгөөд түүнд эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэрийг зааж, Зохицуулах хорооноос тогтоосон загварын дагуу энэ хууль болон даатгалын багц дүрэмд заасан баримт бичгийг хавсаргаж ирүүлнэ.

19.3.Зохицуулах хороо шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээлэл, баримт бичгийг өргөдөл гаргагчаас шаардаж болно.

20 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах

20.1.Зохицуулах хороо дараахь шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид тусгай зөвшөөрлийг олгох бөгөөд тухайн даатгалын төрөл, хэлбэрээс хамааран нэмэлт шаардлага тавьж болно:

20.1.1.өргөдөл гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан, өргөдөл гаргагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшдэг этгээд нь тус тус даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээд бол;

20.1.2.өргөдөл гаргагч нь тусгай зөвшөөрлийг олгосны дараа энэ хууль болон даатгалын багц дүрмийг дагаж мөрдөх бүрэн боломжтой гэдэг нь нотлогдож байна гэж үзвэл;

20.1.3.тухайн даатгалын үйл ажиллагааг эрхлэхэд өргөдөл гаргагчийн удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн эх үүсвэр хангалттай гэж үзвэл;

20.1.4.тусгай зөвшөөрөл олгох нь нийтийн болон даатгуулагчийн ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж үзвэл.

20.2.Зохицуулах хороо даатгалчийн үйл ажиллагааны цар хүрээ, тусгай зөвшөөрлийн төрөл, хэлбэрээс хамааран тусгай зөвшөөрөлд тавигдах нөхцөл шаардлагыг хэдийд ч өөрчлөн тогтоож болно.

20.3.Зохицуулах хороо урт хугацааны болон ердийн даатгалын үйл ажиллагааг нэгэн зэрэг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохгүй.

20.4.Тусгай зөвшөөрлийг бичгээр олгох бөгөөд түүнд дараахь зүйлийг тусгана:

20.4.1.тусгай зөвшөөрлийг олгосон байгууллагын нэр;

20.4.2.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр хаяг;

20.4.3.эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэр;

20.4.4.үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага;

20.4.5.тусгай зөвшөөрлийн дугаар, олгосон огноо;

20.4.6.тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга/тэмдэг/;

20.4.7.давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх эрхтэй эсэх.

20.5.Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгох бөгөөд уг зөвшөөрөл нь энэ хуулийн 69, 70 дугаар зүйлд заасны дагуу түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл хүчин төгөлдөр байна.

20.6.Зохицуулах хороо өргөдөл гаргагчид тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан, эсхүл тусгай зөвшөөрөл олгохыг зөвшөөрсөн боловч даатгалын тодорхой төрөл, хэлбэрийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөөгүй бол энэ тухай бичгээр мэдэгдэж, татгалзсан үндэслэлийг заана.

20.7.Зохицуулах хороо өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 45 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

20.8.Зохицуулах хороо дараахь үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

20.8.1.энэ хуулийн 20.1-д заасан шаардлагыг хангаагүй;

20.8.2.даатгалын багц дүрэмд заасан баримт бичгийг бүрэн ирүүлээгүй;

20.8.3.хуульд заасан бусад үндэслэл.

20.9. Зохицуулах хороо тусгай зөвшөөрөл олгосон тухай даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

20.10. Зохицуулах хороо энэ хуулийн 20.1.1-д заасан "тохиромжтой этгээд"-ийг тодорхойлох зааврыг гаргаж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд тавих хяналт

21 дүгээр зүйл. Даатгагч хөрөнгөө шилжүүлэхэд тавих хяналт

21.1. Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд буй хөрөнгийг Зохицуулах хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

21.2. Аливаа этгээд Зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран шууд буюу шууд бусаар эзэмших, өмчлөхийг хориглоно.

21.3. Даатгагч өөрийн эзэмшил, өмчлөлд буй энэ хуулийн 21.1-д заасан хөрөнгийн талаар Зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр дараахь үйлдэл хийхийг хориглоно:

21.3.1. худалдах, шилжүүлэх, барьцаалах зэргээр захиран зарцуулах, эсхүл захиран зарцуулахыг бусдад зөвшөөрөх;

21.3.2. өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх болон багасгах үр дагаварт хүргэх хувьцаа гаргах, хуваарилах, хувьцаа эзэмшигчдийн эзлэх хувийг бууруулах буюу нэмэгдүүлэх үр дагаварт хүргэх хэлцэл хийх.

21.4. Даатгагч энэ хуулийн 21.3-т заасан үйлдэл хийх зөвшөөрөл хүссэн өргөдлийг Зохицуулах хороонд гаргана.

21.5. Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмших, өмчлөхийг хүсэгч нь ийнхүү эзэмших, өмчлөх тохиромжтой этгээд гэж үзсэн тохиолдолд Зохицуулах хороо даатгагчид зөвшөөрөл олгоно.

21.6. Зохицуулах хороо энэ хуулийн 21.5-д заасан зөвшөөрөл олгохдоо шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл, шаардлага тавьж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр, төлбөрийн чадвар

22 дугаар зүйл. Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээ

22.1. Даатгалын компанийн дүрмийн сан нь мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээ нь 500 сая төгрөг байна. Дүрмийн санг зээлийн хөрөнгөөр бүрдүүлэхийг хориглоно.

22.2. Зохицуулах хороо даатгалын үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээгээс хамааран тухайн даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээг энэ хуулийн 22.1-д заасан хэмжээнээс дээгүүр тогтоож болно.

22.3. Энэ хуулийн 22.2-т заасан дүрмийн сангийн доод хэмжээнд хүрэх боломжит хугацааг даатгагчид олгоно.

22.4. Даатгагчийн дүрмийн сан энэ хуулийн 22.1-д заасан хэмжээнд хүрэхгүй болсон тохиолдолд даатгагч Зохицуулах хороонд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

23 дугаар зүйл. Даатгалын компанийн хувьцаа

23.1. Энэ хуулийг дагаж мөрдсөн өдрөөс хойш даатгалын компанийн гаргасан бүх хувьцааны төлбөрийг мөнгөн хэлбэрээр хийнэ.

23.2. Даатгалын компанид Компанийн тухай хуулийн 45 дугаар зүйл хамаарахгүй.

24 дүгээр зүйл. Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт

24.1. Даатгагч нь дараахь төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг хангасан байна:

24.1.1. даатгалын багц дүрэмд заасан хэмжээнээс багагүй;

24.1.2. энэ хуулийн 24.2-т заасны дагуу Зохицуулах хорооноос тогтоосон хэмжээнээс багагүй.

24.2. Зохицуулах хороо даатгалын үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээгээс хамааран тухайн даатгагчийн төлбөрийн чадварын үзүүлэлтийг энэ хуулийн 24.1.1-д заасан хэмжээнээс дээгүүр тогтоож болно.

24.3. Энэ хуулийн 24.2-т заасан төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтэд хүрэх боломжит хугацааг даатгагчид олгоно.

24.4. Даатгагчийн төлбөрийн чадвар нь энэ хуулийн 24.1-д заасан үзүүлэлтэд хүрэхгүй болсон тохиолдолд даатгагч Зохицуулах хороонд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

25 дугаар зүйл. Даатгалын нөөц сан

25.1. Даатгагч нь гэрээний явцад үүссэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор даатгалын нөөц сан бүрдүүлнэ.

25.2. Даатгалын нөөц сангийн хэмжээ, нөөц санг бүрдүүлэх болон хөрөнгө оруулалтад байршуулах нөхцөлийг даатгалын багц дүрмээр тогтооно.

25.3. Энэ хуулийн 25.1-д заасан даатгалын нөөц сангийн хөрөнгийг тусгайлсан дансанд байршуулна. Дансны бүрдүүлэлт, зарцуулалт Зохицуулах хорооны хяналтад байна.

25.4. Даатгагчийн нөөц санд төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ энэ хуулийн 25.2-т заасан хэмжээнд хүрэхгүй болсон тохиолдолд даатгагч Зохицуулах хороонд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

26 дугаар зүйл. Ногдол ашиг хуваарилах нөхцөл

26.1. Ногдол ашиг хуваарилсны дараа дараах нөхцөлийн аль нэг нь үүсэхээр бол хувь нийлүүлэгчдэд ногдол ашиг хуваарилахгүй:

26.1.1. даатгагчийн дүрмийн сан нь энэ хуулийн 22.1-д заасан хэмжээнд хүрэхгүй;

26.1.2. даатгагчийн төлбөрийн чадвар энэ хуулийн 24.1-д заасан шалгуур, үзүүлэлтийг хангаж чадахгүй;

26.1.3. даатгалын нөөц сан нь энэ хуулийн 25.2-т заасан хэмжээнд хүрэхгүй.

27 дугаар зүйл. Урьдчилгаа болон зээлтэй холбоотой хязгаарлалт

27.1. Даатгагч нь энэ хуулийг дагаж мөрдсөн өдрөөс хойш дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

27.1.1. хувьцаа худалдаж авах, арилжих, мөнгө зээллүүлэх, өөрийн үнэт цаасыг төлбөрийн баталгаа болгож урьдчилгаа авах;

27.1.2. холбогдох этгээдэд аливаа сангаас зээл олгох;

27.1.3. аливаа этгээдэд барьцаагүй зээл олгох;

27.1.4. холбогдох этгээдийн бусдаас авсан зээлд баталгаа, батлан даалт гаргах.

27.2. Энэ хуулийн 27.1-д заасан "холбогдох этгээд"-ийг тодорхойлох зааврыг Зохицуулах хороо гаргаж болно.

27.3. Энэ хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу ногдол ашиг хуваарилахад энэ хуулийн 27.1 дэх хэсэг хамаарахгүй.

28 дугаар зүйл. Даатгагчийн санхүүгийн чадавхид тавих хяналт

28.1. Зохицуулах хороо даатгагчийн санхүүгийн чадавхийг үнэлэх шалгуур тогтоон, шалгалт хийж болно.

28.2. Энэ хуулийн 28.1-д заасны дагуу тогтоосон шалгуурын тухай Зохицуулах хороо даатгагчид бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Нягтлан бодох бүртгэл, аудит

29 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлт болон санхүүгийн тайлан

29.1. Даатгагч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль¹ болон даатгалын багц дүрэмд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.

29.2. Даатгагч нь нягтлан бодох бүртгэлээ ажруул сууриар хөтлөх бөгөөд даатгагчийн үйл ажиллагаанд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.2 дахь хэсэг хамаарахгүй.

29.3. Даатгалын багц дүрэмд өөрөөр заагаагүй бол Зохицуулах хороо даатгагчийн нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг, санхүүгийн тайлангийн агуулга, хэлбэрийг тогтоож болно.

29.4. Санхүүгийн тайлангийн баримт бичиг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.2-т болон даатгалын багц дүрэмд заасан, эсхүл энэ хуулийн 29.3-т заасны дагуу Зохицуулах хорооноос тогтоосон баримт бичгээс бүрдэнэ.

29.5. Даатгагч энэ хуулийн 29.4-т заасан шаардлагыг хангасан санхүүгийн тайланг улирал тутам, аудитаар баталгаажуулсан тухайн жилийн санхүүгийн тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд хэвлэлээр мэдээлнэ.

29.6. Даатгагчийн хүлээсэн үүрэг, эд хөрөнгийг даатгалын багц дүрэмд заасны дагуу үнэлнэ.

29.7. Даатгагч нягтлан бодох бүртгэлийн баримт бичгээ 6 жилээс доошгүй хугацаагаар хадгалах бөгөөд хадгалах газрын хаягийг Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэнэ.

30 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн стандарт мөрдөх

30.1. Даатгагч нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мөрдөнө.

31 дүгээр зүйл. Жил бүрийн санхүүгийн тайлан

31.1. Даатгагч нь аудитаар баталгаажуулсан

¹ "Төрийн мэдээлэл" 2002 оны №2

санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд дараахь баримт бичгийн хамт Зохицуулах хороонд тушаана:

- 31.1.1. удирдлагын тайлан;
- 31.1.2. аудитын дүгнэлт;

31.1.3. урт хугацааны даатгал эрхэлж буй даатгагч (цаашид "урт хугацааны даатгагч" гэх)-ийн хувьд энэ хуулийн 40.1-д заасны дагуу томилсон актуарчийн тайлан;

31.1.4. тухайн санхүүгийн жилд компанийн үйл ажиллагаанд нөлөөлсөн үйл явдлын тухай тодруулга, тайлбар;

31.1.5. даатгалын багц дүрэмд заасан бусад баримт бичиг.

31.2. Жил бүрийн санхүүгийн тайлан болон бусад баримт бичгийн агуулга, хэлбэрийг даатгалын багц дүрмээр тогтоож болно.

31.3. Энэ хуулийн 31.1-д заасан тайлан болон бусад баримт бичгийг Зохицуулах хороонд ирүүлээгүй тохиолдолд санхүүгийн тайланг өгөөгүйд тооцно.

32 дугаар зүйл. Улирал тутмын тайлан

32.1. Даатгагч нь улирал тутмын санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Зохицуулах хороонд тушаана.

32.2. Улирал тутмын санхүүгийн тайлан, холбогдох бусад баримт бичгийн агуулга, хэлбэрийг даатгалын багц дүрмээр тогтоож болно.

32.3. Даатгалын багц дүрэмд заасан баримт бичгийг ирүүлээгүй тохиолдолд санхүүгийн тайланг өгөөгүйд тооцно.

33 дугаар зүйл. Аудит

33.1. Даатгагч нь санхүүгийн тайлангаа баталгаажуулах зорилгоор аудиторыг томилно.

33.2. Энэ хуулийн 33.1-д заасан аудитор нь дараахь шаардлагыг хангасан байна:

33.2.1. Аудитын тухай хуулийн¹ 17 дугаар зүйлд заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй;

33.2.2. даатгагчийн санхүүгийн тайланг баталгаажуулах эрхийг Зохицуулах хорооноос авсан.

33.3. Зохицуулах хороо энэ хуулийн 33.2-т заасан эрх бүхий аудиторын

нэрсийн жагсаалт болон түүнд өөрчлөлт орсон тухай бүр даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

33.4. Даатгагч нь аудиторыг аудитын үйл ажиллагаа явуулах нөхцөл, боломжоор хангана.

33.5. Даатгагч нь аудиторыг томилсноос хойш ажлын 5 хоногийн дотор Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэнэ.

34 дүгээр зүйл. Аудитор актуарчийн тооцоог үндэслэх

34.1. Урт хугацааны даатгагчийн аудитор нь аудитын үйл ажиллагаа явуулахдаа эрх бүхий актуарчийн дараахь тооцоог үндэслэж болно:

34.1.1. тухайн санхүүгийн жилийн эцэст даатгалын гэрээнээс үүссэн үүрэг;

34.1.2. тухайн санхүүгийн жилийн туршид тодорхой сангуудтай холбоотой даатгагчийн хүлээсэн үүрэгт гарсан өөрчлөлт.

35 дугаар зүйл. Аудитын тайлан

35.1. Аудитор нь даатгагчийн санхүүгийн тайлангийн талаархи дүгнэлтийг даатгалын багц дүрэмд заасны дагуу даатгагчид хүргүүлнэ.

35.2. Зохицуулах хороо даатгагчийн эд хөрөнгийн чанар, эрсдлийн сангийн зохистой харьцаа, нягтлан бодох бүртгэл болон хяналтын тогтолцооны зохистой харьцааг тодорхойлох зорилгоор аудитын тайлан гаргаж өгөхийг даатгагчаас хэдийд ч шаардаж болно.

35.3. Энэ хуулийн 35.2-т заасан тайлан бэлтгэхтэй холбогдсон зардлыг даатгагч хариуцна.

36 дугаар зүйл. Аудиторын үүрэг

36.1. Даатгагчийн баримт материалд үндэслэн гаргасан дараахь дүгнэлтийн талаар аудитор нь Зохицуулах хороонд нэн даруй мэдэгдэнэ:

36.1.1. даатгагч төлбөрийн чадваргүй болсон буюу төлбөрийн чадваргүй болж болзошгүй байгаа;

36.1.2. даатгалын үйл ажиллагаатай холбоотой гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдсэн байж болзошгүй;

36.1.3. даатгагч энэ хуулийн 22-27 дугаар зүйлийг ямар нэг хэлбэрээр зөрчсөн гэж үзвэл;

36.1.4. даатгагч энэ хууль, бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрмийг ноцтойгоор зөрчсөн гэж үзвэл.

¹ "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1997 оны №6

36.2. Даатгагч аудитортой байгуулсан гэрээгэ цуцалсан, эсхүл аудитор өөрөө ажиллах боломжгүй гэдгээ мэдэгдэж чөлөөлөгдсөн тохиолдолд аудитор нь Зохицуулах хороонд дараахь асуудлаар мэдээлэл өгнө.

36.2.1. гэрээ цуцалсан буюу чөлөөлөгдсөн тухай, түүний үндэслэлийн талаар;

36.2.2 энэ хуулийн 36.1-д заасан дүгнэлт гаргасан тохиолдолд энэ тухай.

36.3. Зохицуулах хороо аудиторос аудитын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, нэмэлт материал шаардаж болно.

36.4. Аудитор болон аудитор байсан этгээд нь энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан тайлан болон өөрийн зөв гэж үзсэн бусад мэдээллээр Зохицуулах хороог хангасны төлөө түүнийг мэргэжлийн ёс зүйн дүрэм болон хууль тогтоомж зөрчсөн гэж үзэхгүй бөгөөд түүнд эрүүгийн болон бусад хариуцлага ногдуулахгүй.

37 дугаар зүйл. Зохицуулах хорооноос аудиторыг томилох

37.1. Даатгагч энэ хуулийн 33.1-д заасны дагуу аудиторыг томилоогүй бол Зохицуулах хороо аудиторыг томилж болно.

37.2. Энэ хуулийн 37.1-д заасны дагуу томилогдсон аудитор нь даатгагчийн аудиторын энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

38 дугаар зүйл. Компанийн нэгдлийн гишүүдийн нягтлан бодох бүртгэлийн тайланг шаардах

38.1. Даатгагч нь компанийн нэгдлийн гишүүн бол Зохицуулах хороо даатгагчаас тухайн нэгдлийн гишүүн аль ч этгээдийн санхүүгийн болон компанийн нэгдлийн нэгдсэн тайланг шаардаж болно.

38.2. Зохицуулах хороо энэхүү тайланг даатгагчийн аудитор, эсхүл өөрийн томилсон аудитороор баталгаажуулахыг шаардаж болно.

38.3. Энэ хуулийн 38.1-д заасан компанийн нэгдлийн тайлангийн агуулга, хэлбэрийг даатгалын багц дүрмээр тогтоож болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Актуарч, актуарын хяналт шалгалт, тайлан

39 дүгээр зүйл. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох

39.1. Зохицуулах хороо актуарчаар ажиллахад тохирох мэргэжил, дадлага туршлага бүхий Монгол Улсын болон гадаад улсын иргэн,

харьяалалгүй хүнийг сонгон шалгаруулж актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгоно.

39.2. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох ажиллагааг даатгалын багц дүрмийн дагуу хэрэгжүүлнэ.

39.3. Зохицуулах хороо энэ хуулийн 39.1-д заасны дагуу эрх авсан актуарчийн нэрсийн жагсаалт, түүний өөрчлөлтийг даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

40 дүгээр зүйл. Актуарчийг томилохтой холбоотой урт хугацааны даатгагчийн эрх хэмжээ

40.1. Урт хугацааны даатгагч нь заавал актуарчтай байх бөгөөд актуарч нь энэ хуулийн 39.1-д заасны дагуу Зохицуулах хорооноос эрх авсан этгээд байна.

40.2. Даатгагч нь өөрийн актуарчийг томилсон болон чөлөөлсөн тухай бүрт Зохицуулах хороонд ажлын 5 хоногт бичгээр мэдэгдэнэ.

40.3. Актуарчаар томилогдсон этгээд үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон бол ийнхүү боломжгүй болсноос хойш ажлын 30 хоногийн дотор даатгагч өөр актуарчийг томилно.

41 дүгээр зүйл. Актуарчийн дагаж мөрдөх стандарт

41.1. Актуарч нь өөрийн үйл ажиллагаандаа даатгалын багц дүрэмд заасан актуарын стандартыг дагаж мөрдөнө.

42 дугаар зүйл. Актуарын хяналт шалгалт, тайлан

42.1. Урт хугацааны даатгагч нь үйл ажиллагаандаа актуарын хяналт шалгалтыг хоёр жилд нэгээс доошгүй удаа өөрийн актуарчаар хийлгэх үүрэгтэй.

42.2. Энэ хуулийн 42.1-д заасан актуарын хяналт шалгалт нь даатгалын багц дүрэмд заасны дагуу явагдана.

42.3. Зохицуулах хороо даатгагчийн санхүүгийн байдлын талаархи шаардлагатай гэж үзсэн асуудлыг актуарчаар шалгуулах болон актуарын тайлан гаргаж өгөхийг даатгагчаас шаардаж болно.

42.4. Зохицуулах хороо актуарын хяналт шалгалтыг даатгагчийн томилсон, эсхүл өөрийн томилсон актуарчаар гүйцэтгүүлж болно.

42.5. Актуарч нь даатгалын багц дүрэмд заасан агуулга, хэлбэрийн дагуу хяналт шалгалтын тайлан бэлтгэнэ.

42.6.Энэ хуулийн 42.3-т заасан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх болон тайлан бэлтгэхтэй холбогдсон зардлыг даатгагч хариуцна.

43 дугаар зүйл. Актуарчийн эрх

43.1.Актуарч нь дараахь эрхтэй байна:

43.1.1.актуарын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг шалгах;

43.1.2.даатгагчийн талаархи шаардлагатай мэдээлэл, баримт бичиг гаргаж өгөх, асуултад хариулахыг даатгагч, түүний эрх бүхий албан тушаалтан, албан хаагчаас шаардах.

43.2.Актуарч нь компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцож, дараахь асуудлаар үг хэлэх эрхтэй:

43.2.1.даатгагчийн санхүүгийн байдал, нөөцийн сан, төлбөрийн чадвар болон даатгагчийн хөрөнгөд нөлөөлж болох бусад асуудлаар;

43.2.2.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд өгсөн актуарын зөвлөгөөний талаар;

43.2.3.актуарын ажиллагаатай холбоотой асуудлаар.

43.3.Актуарч нь компанийн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож, дараахь асуудлаар үг хэлэх эрхтэй:

43.3.1.даатгагчийн санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн тайлан;

43.3.2.актуарчийн эрх хэмжээ, чиг үүрэгтэй холбоотой аливаа асуудал.

43.4.Актуарч нь дараахь асуудлыг Зохицуулах хороонд мэдэгдэж болно:

43.4.1.энэ хуулийн 43.1.1-д заасан мэдээлэл, баримт бичгийг шалгахад даатгагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр актуарчид дэмжлэг үзүүлэхээс татгалзсан, бусад хэлбэрээр саад учруулсан тухай;

43.4.2.даатгагч, түүний эрх бүхий албан тушаалтан, албан хаагч шаардлагатай мэдээлэл баримт бичиг гаргаж өгөх, асуултад хариулахаас татгалзсан тухай.

44 дүгээр зүйл. Актуарчийн үүрэг

44.1.Актуарч нь даатгагчийн баримт материалд үндэслэн гаргасан дараахь дүгнэлтийн талаар Зохицуулах хороонд нэн даруй мэдэгдэнэ:

44.1.1.даатгагч нь энэ хууль, бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрмийг зөрчсөн, эсхүл зөрчсөн байж болзошгүй;

44.1.2.даатгагч хууль тогтоомж зөрчсөн нь даатгуулагчийн эрх ашигт ноцтой нөлөөлнө гэж үзсэн.

44.2.Актуарч нь даатгагчийн санхүүгийн байдал, нөөцийн сан, төлбөрийн чадвар, даатгагч болон даатгуулагчийн ашиг сонирхолд нөлөөлж болох аливаа асуудлаар шаардлагатай арга хэмжээ авах талаар даатгагчид мэдэгдэх үүрэгтэй.

44.3.Актуарч энэ хуулийн 44.2-т заасны дагуу даатгагчид мэдэгдсэн бөгөөд тогтоосон хугацаанд даатгагч ямар нэг арга хэмжээ аваагүй бол энэ тухай Зохицуулах хороонд нэн даруй мэдэгдэнэ.

44.4.Даатгагч актуарчтай байгуулсан гэрээгээ цуцалсан, эсхүл өөрөө ажиллах боломжгүй гэдгээ мэдэгдэж чөлөөлөгдсөн тохиолдолд актуарч нь Зохицуулах хороонд дараахь асуудлаар мэдээлэл өгнө:

44.4.1.гэрээ цуцалсан буюу чөлөөлөгдсөн тухай, түүний үндэслэлийн талаар;

44.4.2.энэ хуулийн 44.1, 44.3-т заасан мэдээллийн тухай.

44.5.Актуарч болон актуарч байсан этгээд тайлан болон энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасан өөрийн зөв гэж үзсэн бусад мэдээллээр Зохицуулах хороог хангасны төлөө түүнийг мэргэжлийн ёс зүйн дүрэм болон хууль тогтоомж зөрчсөн гэж үзэхгүй бөгөөд түүнд эрүүгийн болон бусад хариуцлага ногдуулахгүй.

45 дугаар зүйл. Зохицуулах хороо актуарчийг томилох

45.1.Урт хугацааны даатгагч нь актуарчийг томилоогүй бол Зохицуулах хороо энэ хуулийн 39.1-д заасан актуарын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийг актуарчаар томилно.

45.2.Энэ хуулийн 45.1-д заасны дагуу томилогдсон актуарч нь урт хугацааны даатгагчийн актуарчийн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Давхар даатгал

46 дугаар зүйл. Давхар даатгалд даатгуулах

46.1.Даатгагч нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ дараахь даатгагчид даатгуулж болно:

46.1.1.энэ хуулийн дагуу давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанид;

46.1.2.энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл аваагүй гадаад улсын даатгалын компанид.

47 дугаар зүйл. Даатгагчийн давхар даатгалын гэрээ

47.1 Даатгагч даатгалын эрсдлийг хариуцах үүргээ давхар даатгуулах төлөвлөгөөг даатгалын багц дүрэмд заасны дагуу Зохицуулах хороогоор батлуулна.

47.2. Зохицуулах хороо тухайн төрлийн давхар даатгалын гэрээнд энэ хуулийн 47.1-д заасан давхар даатгалын төлөвлөгөөг батлуулахад тавигдах шаардлага хамаарахгүй байхаар бичгээр тогтоож болно.

48 дугаар зүйл. Давхар даатгалын тайлан

48.1 Даатгагч нь давхар даатгалын төлөвлөгөөний нарийвчилсан тайланг тогтоосон хугацаанд гаргаж Зохицуулах хороонд хүргүүлэх бөгөөд тайланд давхар даатгалын гэрээний хуулбарыг хавсаргана.

АРАВДУГААР БҮЛЭГ

Даатгагчийн үүрэг, даатгагчид тавих хязгаарлалт

49 дүгээр зүйл. Даатгагч зөвхөн даатгалын үйл ажиллагаа эрхлэх

49.1 Даатгагч нь Монгол Улсад болон гадаад улсад гагцхүү даатгалын үйл ажиллагаа болон түүнтэй холбоотой үйл ажиллагаа эрхэлнэ.

49.2 Даатгагчийн эрхлэх даатгалтай холбоотой үйл ажиллагааг даатгалын багц дүрмээр тодорхойлно.

50 дугаар зүйл. Даатгагч бизнес төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх

50.1 Даатгагч үйл ажиллагаагаа Зохицуулах хорооноос хамгийн сүүлд баталсан бизнес төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

50.2 Даатгагч бизнес төлөвлөгөөндөө нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтээ хэзээ ч гаргаж болох бөгөөд энэ тухай хүсэлтээ шинэчлэгдсэн бизнес төлөвлөгөөний төслийн хамт Зохицуулах хороонд хүргүүлнэ.

50.3 Зохицуулах хороо хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 20 хоногийн дотор шинэчлэгдсэн бизнес төлөвлөгөөг батлах эсэхийг шийдвэрлэнэ.

50.4 Зохицуулах хороо даатгагчийн шинэчлэгдсэн бизнес төлөвлөгөөг батлах эсэх асуудлыг шийдвэрлэх явцдаа даатгагчаас нэмэлт материал шаардаж болно.

51 дүгээр зүйл. Урт хугацааны даатгагчийн сан байгуулах, түүнийг зарцуулах

51.1 Урт хугацааны даатгагч нь эрхэлж буй даатгалын төрөл тус бүрт тусгайлсан данс нээж, тусгайлсан сан байгуулна.

51.2 Урт хугацааны даатгагчийн хөтлөх нягтлан бодох бүртгэлийн болон бусад тайланд дараахь үзүүлэлтийг тус тусад нь гаргаж харуулна:

51.2.1 сан тус бүрд хамаарах хөрөнгө;

51.2.2 даатгалын төрөл тус бүрд хамаарах үүрэг.

51.3 Тухайн сангийн хөрөнгийг зөвхөн тухайн төрлийн даатгалын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулах бөгөөд сангийн хөрөнгийг хооронд нь шилжүүлэн зарцуулахыг хориглоно.

51.4 Дараахь тохиолдолд энэ хуулийн 51.3 дахь хэсэг хамаарахгүй:

51.4.1 тухайн сангийн хөрөнгийг үнэлгээ нь актуарын тооцоогоор тухайн төрлийн даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээс хэтэрч байвал ийнхүү хэтэрсэн хэсэгт;

51.4.2 урт хугацааны даатгагчийн сангийн хөрөнгийг зах зээлийн үнээр нь өөр хөрөнгөөр солиход.

51.5 Энэ хуулийн 51.4.1-д зааснаас бусад тохиолдолд урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэхэд зориулж байгуулсан сангийн хөрөнгийг даатгагчийн өөр үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно.

51.6 Урт хугацааны даатгалын гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэхэд урт хугацааны даатгагчийн сангийн хөрөнгийн хэмжээ хүрэхгүй болсон тохиолдолд даатгагч, түүний хараат болон охин компани ногдол ашиг төлөх болон төлөхөөр зарлахыг хориглоно.

51.7 Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон компанид энэ хуулийн 51 дүгээр зүйл нэгэн адил хамаарна.

52 дугаар зүйл. Тодорхойгүй хэлцлээс зайлсхийх

52.1 Энэ хуулийг дагаж мөрдсөн өдрөөс хойш даатгалын байгуулсан хариуцлагын хэмжээ, эсхүл дээд хэмжээ нь тодорхойгүй даатгалын гэрээ энэ хуулийн 52.2-т зааснаас бусад тохиолдолд хүчин төгөлдөр бус байна.

52.2 Энэ хуулийн 52.1-д үл хамаарах даатгалын гэрээний төрөл, хэлбэрийг даатгалын багц дүрмээр тогтоож болно.

53 дугаар зүйл. Даатгагчийн ерөнхий захиргааны хаяг

53.1.Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан даатгалын компанийн ерөнхий захиргаа нь Монгол Улсад байрлах бөгөөд даатгагч нь ерөнхий захиргааныхаа хаягийг Зохицуулах хороонд мэдэгдэнэ.

53.2.Даатгагч нь ерөнхий захиргааныхаа хаягийг өөрчилбөл ажлын 5 хоногийн дотор Зохицуулах хороонд мэдэгдэнэ.

54 дүгээр зүйл. Салбар, төлөөлөгчийн газар нээх

54.1.Даатгагч нь өөрийн салбар, төлөөлөгчийн газраа гадаад улсын нутаг дэвсгэрт нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа явуулахдаа Зохицуулах хорооноос бичгээр зөвшөөрөл авна.

54.2.Гадаадын даатгагч Зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

54.3.Гадаадын даатгагч Зохицуулах хорооноос бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд аливаа этгээд гадаадын даатгагчийг төлөөлж дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

54.3.1.даатгалын үйл ажиллагаа явуулах зорилгоор сурталчилгаа, ухуулга хийх, эсхүл ийм зорилгоор албан байр нээж ажиллуулах;

54.3.2.салбар, төлөөлөгчийн газар нээх, ажиллуулах.

54.4.Зохицуулах хороо энэ хуулийн 54.1-д заасан зөвшөөрөл хүссэн өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэхдээ нэмэлт мэдээлэл, баримтыг даатгагчаас шаардаж болно.

54.5.Энэ хуулийн 54.2-т заасан зөвшөөрөл олгохдоо Зохицуулах хороо тодорхой нөхцөл, шаардлага тавьж болох бөгөөд эдгээр нөхцөл, шаардлагаа хэдийд ч өөрчилж болно.

55 дугаар зүйл. Эрх бүхий албан тушаалтныг томилох

55.1.Даатгагч нь Зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн компанийн эрх бүхий албан тушаалтныг томилоно.

55.2.Зохицуулах хороо нь тухвйн этгээд компанийн уг албан тушаалд тохирно гэж үзвэл энэ хуулийн 55.1-д заасан зөвшөөрлийг олгоно.

55.3.Даатгагчийн эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх дуусгавар болсон, эсхүл хүсэлтээрээ чөлөөлөгдсөн тохиолдолд даатгагч энэ тухай ажлын 5 хоногийн дотор Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэнэ.

56 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлгүй

даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчид төлбөр төлөхийг хориглох

56.1.Даатгагч нь даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй этгээдэд аливаа төлбөр, хураамж төлөхийг хориглоно.

57 дугаар зүйл. Мэдээллийг өөрчлөх

57.1.Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч байгаа этгээд, эсхүл даатгагч болон бусад этгээдээс энэ хууль, даатгалын багц дүрэмд заасны дагуу Зохицуулах хороонд гаргаж буй аливаа зөвшөөрөл хүссэн өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэхээс өмнө Зохицуулах хороонд ирүүлсэн мэдээлэл, баримтад өөрчлөлт орвол зөвшөөрөл хүссэн этгээд энэ тухай нэн даруй бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Зах зээлийн ёс зүй

58 дугаар зүйл. Төөрөгдүүлсэн зар сурталчилгаа

58.1.Даатгагч нь төөөрөгдүүлсэн, эсхүл худал мэдээлэл агуулсан зар сурталчилгаа, мэдээлэл, төвхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг гаргах, тараах, тараахыг зөвшөөрөхийг хориглоно.

58.2.Даатгагчийн болон түүний нэрийн өмнөөс гаргасан мэдээлэл, төвхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг нь төөөрөгдүүлсэн буюу худал мэдээлэл агуулсан, эсхүл нийтийн ашиг сонирхолд харшилсан гэж үзвэл Зохицуулах хороо тухайн баримт бичгийг гаргахыг хориглох, няцаахыг даалгах, эсхүл шаардлагатай гэж үзсэн өөрчлөлт, залруулга хийж гаргахыг бичгээр даалгана.

59 дүгээр зүйл. Зах зээлийн ёс зүй

59.1.Зохицуулах хороо даатгагчийн дагаж мөрдвөл зохих зах зээлийн ёс зүйн журмыг гаргаж болох бөгөөд даатгагч, түүний эрх бүхий албан тушаалтан болон даатгалын үйл ажиллагаанд оролцогч түүнийг дагаж мөрдөх үүрэгтэй.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ

Нэрэнд хяналт тавих

60 дугаар зүйл. "Даатгал" гэсэн нэр томъёог хэрэглэхийг хязгаарлах

60.1.Даатгагч нь оноосон нэртэй байх бөгөөд уг нэрийн ард "даатгал" гэсэн үгийг заавал хэрэглэнэ.

60.2.Энэ хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчээс бусад этгээд "даатгал", эсхүл

"даатгал" гэсэн үгний төрөл үг хэрэглэх, даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа, эсхүл үг үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан гэсэн сэтгэгдэл төрүүлэхүйц нэр томъёо ашиглах болон тэдгээртэй адилтгах бусад үйлдэл хийхийг хориглоно.

60.3 Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд заасны дагуу даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрөлтэй компанид энэ хуулийн 60.1 дэх хэсэг хамаарахгүй бөгөөд тэдгээрийн нэр нь зөвхөн тухайн төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг болохыг илэрхийлсэн байвал зохино.

АРВАНГУРАВДУГААР БҮЛЭГ

Хяналт шалгалт, мэдээлэл цуглуулах, тайлагнах

61 дүгээр зүйл. Үйл ажиллагааны шалгалтад хамаарах холбогдох этгээд

61.1. Энэ хуулийн арвангуравдугаар бүлэгт заасан "холбогдох этгээд" гэдэгт даатгагч болон даатгагч байсан этгээд, эсхүл түүний хараат болон охин компани хамаарна.

62 дугаар зүйл. Холбогдох этгээдийн үйл ажиллагаанд хийх шалгалт

62.1. Зохицуулах хороо холбогдох этгээдийн үйл ажиллагааг энэ хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд шалгах зорилгоор дараахь арга хэмжээг хэдийд ч авч хэрэгжүүлж болно:

62.1.1. холбогдох этгээдийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, баримт бичгийг шалгах;

62.1.2. холбогдох этгээдийн хяналт болон эзэмшилд буй эд хөрөнгө, бэлэн мөнгө зэргийг шалгах, тоолох;

62.1.3. холбогдох этгээдийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон бусад баримт бичгийг хуулбарлан авч хянаж шалгах.

62.2. Зохицуулах хороо шаардлагатай гэж үзвэл холбогдох этгээдэд хяналт тавихтай холбоотой дараахь асуудлыг судлан үзэж болно:

62.2.1. нөөцийн сан, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт болон хөрөнгийг шалгах;

62.2.2 энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрэм болон Зохицуулах хорооноос тавьсан шаардлага, үүрэг даалгаврыг биелүүлж байгаа эсэх.

62.3. Зохицуулах хороо үйл ажиллагааны шалгалтын удирдамжийг холбогдох этгээдэд урьдчилан танилцуулна.

62.4. Зохицуулах хороо шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагааны шалгалтыг хэрэгжүүлэхдээ тохирох дадлага туршлага, мэргэжил бүхий этгээдийг татан оролцуулж болно.

62.5. Үйл ажиллагааны шалгалтыг хоёр жилд нэгээс доошгүй удаа холбогдох этгээдийн өдөр тутмын үйл ажиллагаанд саад болохгүйгээр зохион байгуулна.

63 дугаар зүйл. Үйл ажиллагааны шалгалттай холбоотой холбогдох этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтны үүрэг

63.1. Холбогдох этгээд үйл ажиллагааны шалгалтын үед дараахь үүрэг хүлээнэ:

63.1.1. өөрийн байранд нэвтрэх, эд хөрөнгийг шалгах боломжоор хангах;

63.1.2. нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон холбогдох бусад баримт бичгийг гаргаж өгөх;

63.1.3. шаардлагатай мэдээлэл, тайлбараар хангах;

63.1.4. шаардлагатай баримт бичгийг бусад этгээдээс олж авч Зохицуулах хороонд өгөх.

63.2. Зохицуулах хороо шаардлагатай мэдээлэл, тайлбар гаргаж өгөхийг холбогдох этгээдийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнаас бичгээр шаардаж болно.

64 дүгээр зүйл. Шалгалтын тайлан

64.1. Зохицуулах хороо нь үйл ажиллагааны шалгалт дууссанаас хойш ажлын 45 хоногийн дотор шалгалтын товч тайланг холбогдох этгээдэд хүргүүлнэ.

64.2. Шалгалтын тайланд дараахь зүйлийг тусгана:

64.2.1. холбогдох этгээдийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хяналт болон шаардлагатай гэж үзсэн бусад асуудлын талаархи зөвлөмж;

64.2.2. тайлантай холбогдуулан холбогдох этгээдээс хариу шаардаж байгаа эсэх, хариу шаардаагүй бол тайланд онцгойлон үзэж буй асуудлын талаар.

64.3. Шалгалтын тайлантай холбогдуулан хариу шаардсан бол холбогдох этгээд тайланг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор, эсхүл тайланд тусгайлан заасан хугацаанд Зохицуулах хороонд хариу мэдэгдэх үүрэгтэй.

65 дугаар зүйл. Зохицуулах хорооны мэдээлэл цуглуулах эрх

65.1. Зохицуулах хороо энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан бүрэн

эрхээ хэрэгжүүлэх зорилгоор, эсхүл гадаадын зохицуулах байгууллагын тавьсан хүсэлтийн дагуу энэ хуулийн 65.2-т заасан этгээдээс дараахь зүйлийг бичгээр шаардаж болно:

65.1.1. тодорхой төрлийн буюу тусгайлан заасан мэдээлэл гаргаж өгөхийг;

65.1.2. тодорхой төрлийн буюу тусгайлан заасан баримт бичиг гаргаж өгөхийг.

65.2. Энэ хуулийн 65.1-д заасан мэдэгдлийг холбогдох этгээд болон түүнтэй холбоотой этгээд, даатгагч, эсхүл мэдэгдэлтэй холбоотой мэдээлэл, баримт бичиг байгаа гэж үзсэн этгээдэд өгөх бөгөөд мэдэгдэлд мэдээлэл, баримт бичгийг гаргаж өгөх буюу үйлдэх хугацаа, газрыг заана.

65.3. Энэ хуулийн 65.2-т заасан "холбоотой этгээд"-ийг даатгалын багц дүрмээр тодорхойлно.

65.4. Зохицуулах хороо энэ хуулийн 65.1-д заасан эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь шаардлагыг тавьж болно:

65.4.1. тогтоосон хэлбэр, загвараар мэдээлэл бэлтгэж ирүүлэхийг;

65.4.2. уг мэдээлэл, баримт бичгээ баталгаажуулахыг;

65.4.3. уг мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан тайлбар гаргахыг.

65.5. Зохицуулах хороо энэ хуульд заасны дагуу мэдээлэл цуглуулахдаа холбогдох баримт бичгийг түүвэрлэн буюу хуулбарлан авч болно.

65.6. Зохицуулах хорооноос энэ хуулийн 65.1-д заасны дагуу мэдээлэл, баримт бичгээр хангахыг даалгасан мэдэгдлийг хүлээн авсан этгээд заавал биелүүлэх үүрэгтэй.

66 дугаар зүйл. Гадаадын зохицуулах байгууллагад тусалцаа үзүүлэх

66.1. Гадаадын зохицуулах байгууллага өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан тусалцаа үзүүлэхийг бичгээр хүссэн тохиолдолд Зохицуулах хороо энэ хуулийн 66 дугаар зүйлд заасны дагуу холбогдох, мэдээлэл, баримт бичгээр хангаж болно.

66.2. Гадаадын зохицуулах байгууллагыг мэдээлэл, бичиг баримтаар хангах эсэхийг шийдвэрлэхдээ дараахь асуудлыг анхаарна:

66.2.1. Гадаадын зохицуулах байгууллага нь уг асуудалтай төстэй асуудлаар харилцан тусалцаа үзүүлж байсан, эсхүл үзүүлэх эсэх;

66.2.2. Монгол Улсын хууль тогтоомж, нийтийн ашиг сонирхолд нийцэж байгаа эсэх;

66.2.3. асуудлын шинж чанар, тухайн асуудал Монгол Улсын хувьд ач

холбогдолтой эсэх;

66.2.4. мэдээлэл бэлтгэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг гадаадын зохицуулах байгууллага төлсөн эсэх;

66.2.5. энэ хуулийн 81 дүгээр зүйлд заасны дагуу мэдээллийн нууцлалыг хангаж чадах эсэх.

66.3. Зохицуулах хороо гадаадын зохицуулах байгууллагын хүссэн мэдээлэлтэй холбогдуулж тодруулга ирүүлэхийг уг байгууллагаас хүсэж болно.

66.4. Гадаадын зохицуулах байгууллага энэ хуулийн 66.3-т заасан хүсэлтэд хариу ирүүлээгүй бол Зохицуулах хороо түүнд тусалцаа үзүүлэхээс татгалзаж болно.

АРВАНДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Албадлага

67 дугаар зүйл. Албадлагын арга хэмжээ авах үндэслэл

67.1. Зохицуулах хороо дараахь үндэслэлээр даатгагчид албадлагын арга хэмжээ авч болно:

67.1.1. энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрмийг зөрчсөн;

67.1.2. даатгуулагчийн болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулахуйц нөхцөл байдал үүссэн;

67.1.3. даатгагч төлбөрийн чадваргүй болсон буюу төлбөрийн чадваргүй болж болзошгүй гэж үзвэл;

67.1.4. Зохицуулах хорооноос энэ хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу өгсөн даалгаврыг биелүүлээгүй;

67.1.5. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн, тусгай зөвшөөрлийг хуурамч баримт бичиг бүрдүүлэн авсан нь тогтоогдсон;

67.1.6. тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний удирдах албан тушаалтан, компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээд нь тус тус тохиромжтой бус этгээд гэж үзсэн;

67.1.7. даатгагч татан буугдсан;

67.1.8. нягтлал бодох бүртгэл, санхүүгийн тайлангаа зохих ёсоор хөтлөөгүй;

67.1.9. даатгалын үйл ажиллагааг зохистой явуулаагүй;

67.1.10. холбогдох этгээдийн үйл ажиллагааг шалгах явцад Зохицуулах хороотой хамтран ажиллахаас татгалзсан;

67.1.11. даатгалын эрсдлээ

хязгаарлах зорилгоор давхар даатгалын төлөвлөгөө хийгээгүй, эсхүл давхар даатгалын төлөвлөгөө нь даатгалын багц дүрэмд заасан шаардлага хангахгүй;

67.1.12. бизнес төлөвлөгөөг дагаж мөрдөөгүй буюу хамгийн сүүлд баталсан бизнес төлөвлөгөөг ноцтойгоор зөрчсөн;

67.1.13. Зохицуулах хорооноос ногдуулсан торгуулийг хугацаанд нь төлөөгүй;

67.1.14. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

68 дугаар зүйл. Албадлагын арга хэмжээний төрөл

68.1. Зохицуулах хороо энэ хуулийн 67.1-д заасан үндэслэлээр дараахь төрлийн албадлагын арга хэмжээг хэрэглэнэ:

68.1.1. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх;

68.1.2. тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

68.1.3. энэ хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу шалгагч томилох;

68.1.4. энэ хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу даалгавар өгөх;

68.1.5. даатгалын үйл ажиллагааг зохистой явуулах талаар зөвлөх үүрэг бүхий давдлага туршлагатай мэргэжилтэн томилох;

68.1.6. торгох.

69 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

69.1. Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг дараахь үндэслэлээр түдгэлзүүлнэ:

69.1.1. энэ хуулийн 67.1-д заасан үндэслэлийн аль нэг нь илэрсэн;

69.1.2. тусгай зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын дотор үйл ажиллагаагаа эхлээгүй, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон;

69.1.3. тусгай зөвшөөрлийн жил бүрийн төлбөрийг төлөх хугацаа өнгөрснөөс хойш 2 сарын дотор төлөөгүй.

69.2. Тусгай зөвшөөрлийг дараахь хугацаагаар түдгэлзүүлнэ:

69.2.1. Зохицуулах хорооноос тогтоосон хугацаагаар;

69.2.2. Зохицуулах хорооноос тавьсан шаардлага, өгсөн даалгаврыг биелүүлэх хүртэл.

69.3. Энэ хуулийн 69.2.1-д заасан хугацаа нь 6 сараас хэтрэхгүй

69.4. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлснээс хойш энэ хуулийн 69.2.2-т заасан шаардлагыг 6

сарын дотор биелүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

69.5. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхээс өмнө Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэлийг заасан мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хургуулж, хүргэсэн огноог тэмдэглэнэ.

69.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 69.5-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Зохицуулах хороонд бичгээр ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

69.7. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд дараахь агуулга бүхий мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлнэ:

69.7.1. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай;

69.7.2. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн үндэслэл, түдгэлзүүлж эхэлсэн огноо;

69.7.3. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаа.

70 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

70.1. Зохицуулах хороо дараахь үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

70.1.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

70.1.2. даатгалын компани татан буугдсан;

70.1.3. тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

70.1.4. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

70.1.5. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй.

70.2. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохоос өмнө Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох болсон үндэслэлийг заасан мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хургуулж, хүргэсэн огноог тэмдэглэнэ.

70.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Зохицуулах хороонд бичгээр ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

70.4. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд дараахь агуулга бүхий мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлнэ:

70.4.1. тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай;

70.4.2. тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон үндэслэл; огноо.

71 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосноос үүсэх үр дагавар

71.1. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш даатгагч Зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр дараахь үйлдэл хийхийг хориглоно:

71.1.1. шинээр даатгалын гэрээ байгуулах;

71.1.2. тухайн өдрөөс өмнө байгуулсан даатгалын гэрээг шинэчлэх, өөрчлөх.

71.2. Шаардлагатай гаж үзвэл даатгагч нь даатгалын гэрээгээр хүлээсэн үүрэг, давхар даатгалын хураамжийн төлбөр болон гэрээнээс үүссэн бусад зардлыг төлөх төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.

71.3. Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон талаархи мэдээллийг даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

72 дугаар зүйл. Зохицуулах хороо даатгагчийн эд хөрөнгийг хамгаалах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах

72.1. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон, эсхүл энэ хуулийн 69.1, 70.1-д заасан үндэслэл байна гэж үзвэл нийтийн болон эзэгдүүлэгч, даатгуулагчийн ашиг сонирхол, даатгагчийн өмч хөрөнгө, үйл ажиллагааг хамгаалах зорилгоор Зохицуулах хороо шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

72.2. Зохицуулах хороо энэ хуулийн 72.1-д заасан нэхэмжлэл гаргахдаа даатгагчид мэдэгдэх үүрэг хүлээхгүй.

72.3. Даатгагчийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлээгүй, эсхүл хүчингүй болгоогүй бол нэхэмжлэлийг энэ хуулийн 69.5, 70.2-т заасан тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгох тухай мэдэгдлийг даатгагчид өгөхөөс өмнө гаргаж болно.

72.4. Энэ хуулийн 72.1-д заасан нэхэмжлэлийн дагуу шүүх дараахь арга хэмжээг хэрэгжүүлж болно:

72.4.1. даатгагч болон бусад этгээдийн эзэмшилд буй өмч хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах зэрэг хэлцэл хийхийг хориглосон шийдвэр гаргах;

72.4.2. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгохоос өмнө

даатгагчийн үйл ажиллагааг удирдан зохицуулах бүрэн эрхт төлөөлөгчийг нэн даруй томилох;

72.4.3. компанийг татан буулгах; үйл ажиллагаатай холбоотой асуудлаар мэдээлэл авахаар холбогдох этгээдийг дуудан ирүүлэх.

72.5. Шүүх энэ хуулийн 72.4.2-т заасан бүрэн эрхт төлөөлөгчийг томилохдоо түүний эрх хэмжээ, цалин хөлс, шүүх болон Зохицуулах хороонд тайлан мэдээ гаргаж өгөх журмыг тогтооно.

72.6. Шүүх бүрэн эрхт төлөөлөгчийн талаар дараахь арга хэмжээг хэдийд ч авч болно:

72.6.1. эрх үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан даалгавар, зааварчилга өгөх;

72.6.2. эрх хэмжээг нь өөрчлөх;
72.6.3. бүрэн эрхийг нь дуусгавар болгох.

73 дугаар зүйл. Даалгавар

73.1. Зохицуулах хороо даатгагчид албадлагын арга хэмжээ авахдаа дараахь агуулга бүхий даалгаврыг өгч болно:

73.1.1. даатгалын тодорхой ангилал, төрөл, хэлбэрийн үйл ажиллагаа эрхлэхийг түр зогсоох;

73.1.2. даатгалын тодорхой ангилал, төрөл, хэлбэртэй холбоотой шинээр гэрээ байгуулахыг хориглох;

73.1.3. байгуулсан даатгалын гэрээг өөрчлөхийг хориглох;
73.1.4. даатгалын нийт хураамжийн хэмжээг даалгаварт заасан хэмжээгээр тогтоох;

73.1.5. тодорхой төрлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулахыг хориглох;

73.1.6. тодорхой хугацааны дотор өөрийн эзэмшилд буй хөрөнгө оруулалтыг чөлөөлөх;

73.1.7. хуульд заасан хугацаанаас өмнө санхүүгийн хяналт шалгалт хийх, шалгалттай холбогдуулан актуарч болон бусад этгээдийг томилох;

73.1.8. шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг энэ хууль, бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрэмд зааснаас богино хугацаанд гаргаж өгөх;

73.1.9. бизнес төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

73.1.10. даатгуулагч болон хувь нийлүүлэгчийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор

шаардлагатай гэж үзсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

73.2.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон бол шаардлагатай гэж үзсэн бусад даалгаврыг өгч болно.

73.3.Энэ хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу Зохицуулах хорооноос өгч буй аливаа даалгаврыг даатгагч биелүүлэх үүрэгтэй.

73.4.Тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон этгээдэд энэ хуулийн 73 дугаар зүйл нэгэн адил хамаарна.

74 дүгээр зүйл. Шалгагчийг томилох

74.1.Зохицуулах хороо энэ хуулийн 67.1-д заасан үндэслэлээр албадлагын арга хэмжээ авахдаа тухайн этгээдийн үйл ажиллагааг хянан шалгах үүрэг бүхий нэг буюу хэд хэдэн этгээдийг шалгагчаар томилж болно.

74.2.Энэ хуулийн 74.1-д заасны дагуу томилогдсон шалгагч нь дараахь асуудлыг хянан шалгаж болно:

74.2.1.даатгагчийн үйл ажиллагаа, түүний шинж чанар;

74.2.2.даатгагчийн үйл ажиллагааны тодорхой асуудлууд;

74.2.3.даатгагчийн болон хувь нийлүүлэгчдийн хяналт.

74.3.Шалгагч нь шаардлагатай гэж үзвэл тухайн этгээдийн үйл ажиллагаа болон компанийн нэгдлийн бусад гишүүдийн үйл ажиллагааг хэдий ч шалгаж болно.

74.4.Шалгагчийн томилолтын хугацаа болон нөхцөлийг Зохицуулах хороо өөрийн үзэмжээр тогтооно.

АРВАНТАВДУГААР БҮЛЭГ

Даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх, нэгтгэх

75 дугаар зүйл. Даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх болон нэгтгэх

75.1.Даатгагч даатгалын үйл ажиллагаагаа шилжүүлэх болон нэгтгэх хүсэлтээ Зохицуулах хороонд гаргаж бичгээр зөвшөөрөл авна.

75.2.Зохицуулах хорооноос бичгээр зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд даатгагчид дараахь зүйлийг хориглоно:

75.2.1.даатгагчийн үйл ажиллагааны аливаа хэсгийг бусад этгээдэд шилжүүлэх;

75.2.2.даатгагчийн үйл ажиллагааны аливаа хэсгийг бусад этгээдийн үйл ажиллагаатай нэгтгэх.

75.3.Энэ хуулийн 75 дугаар зүйлд заасны дагуу шилжүүлэх болон нэгтгэх тухай өргөдөл гаргах, өргөдлийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон үйл ажиллагааг даатгалын багц дүрмээр зохицуулна.

75.4.Шилжүүлэх болон нэгтгэх тухай зөвшөөрлийг олгохоос өмнө Зохицуулах хороо дараахь арга хэмжээг авч болно:

75.4.1.шилжүүлэх болон нэгтгэх нь зохимжтой эсэх талаар судлах;

75.4.2.даатгагч болон бусад этгээдээс шаардлагатай гэж үзсэн баримт бичиг, мэдээллийг шаардаж авах.

75.5.Энэ хуулийн 75.4.1-д заасныг Зохицуулах хороо буюу түүний эрх олгосон этгээд хэрэгжүүлэх бөгөөд зардлыг даатгагч хариуцна.

75.6.Зохицуулах хорооны зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагааны аливаа хэсгийг бусдад шилжүүлэх, эсхүл бусдын үйл ажиллагаатай нэгтгэх үр дагавар бүхий даатгагчийн байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

75.7.Зохицуулах хороо нь даатгалын үйл ажиллагааны аливаа хэсгийг бусдад шилжүүлэх болон нэгтгэх тухай гаргасан өргөдлийг нээлттэй хурлаар хэлэлцэж болох бөгөөд даатгагч болон бусад этгээдээс шаардлагатай нотлох баримт шаардаж болно.

АРВАНЗУРГАДУГААР БҮЛЭГ

Даатгагчийг татан буулгах

76 дугаар зүйл. Даатгагчийн дампуурал

76.1.Даатгагчид дампуурлын хэрэг үүсгэхтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Дампуурлын тухай хуулийн дагуу зохицуулна.

76.2.Шүүх дараахь асуудлын талаар Зохицуулах хороонд мэдэгдэх бөгөөд Зохицуулах хороо уг асуудлыг хэлэлцэхэд оролцох, тайлбар өгөх эрхтэй.

76.2.1.Дампуурлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу даатгагчид дампуурлын хэрэг үүсгүүлэх тухай шүүхэд гаргасан нэхэмжлэл болон хүсэлт;

76.2.2.Дампуурлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу даатгагчид дампуурлын хэрэг үүсгэсэнтэй холбоотой гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гаргаж буй аливаа гомдол;

76.2.3.даатгагчийн дампууралтай холбоотой Дампуурлын тухай хуулийн дагуу шүүхээс шийдвэрлэж буй бусад асуудал.

76.3. Даатгагчид дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт гаргасан тохиолдолд Зохицуулах хороо Дампуурлын тухай хуулийн 5.7-д заасан хэрэг гүйцэтгэчийг түр томилуулахаар хүсэлт гаргаж болох бөгөөд түүнд тохирох мэргэжил, дадлага туршлага бүхий хүнийг санал болгож болно.

76.4. Даатгагч дампуурсан тухайгаа зарласан тохиолдолд Зохицуулах хороо тохирох мэргэжил, дадлага туршлага бүхий хүнийг хэрэг гүйцэтгэгчээр томилуулахаар шүүхэд санал тавих бөгөөд энэ тохиолдолд Дампуурлын тухай хуулийн 8.2 дахь хэсэг үйлчлэхгүй.

76.5. Шүүх Зохицуулах хорооноос санал болгосон этгээдийг хэрэг гүйцэтгэгчээр томилж болно.

76.6. Хэрэг гүйцэтгэгч болон хэрэг гүйцэтгэгчээр түр томилогдсон этгээд нь Дампуурлын тухай хуулийн 11.2-т заасан шаардлагыг хангасан байхаас гадна даатгалын компанийн үйл ажиллагааны онцлогийн талаар зохих мэдлэгтэй байна.

76.7. Зохицуулах хороо нь Дампуурлын тухай хуулийн 8.3.3, 8.3.4, 8.3.6-д заасан асуудлаар шийдвэр гаргах эрхтэй.

76.8. Хэрэг гүйцэтгэгч нь өөрийн үйл ажиллагааны тухай Зохицуулах хорооны шаардлагатай гэж үзсэн мэдээлэл, тайлан гаргаж өгөх үүрэгтэй.

76.9. Зохицуулах хороо хариуцагч болон хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагааны талаар шүүхэд хэдийд ч гомдол гаргах эрхтэй.

76.10. Хариуцагч нь даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа бол Дампуурлын тухай хуульд заасан аливаа хугацааг шүүх өөрийн үзэмжээр сонгах эрхтэй.

77 дугаар зүйл. Даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх

77.1. Дампуурлын тухай хуулийн 23.1-д заасны дагуу даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргаж байгаа, мөн хуулийн 24.1-д заасны дагуу даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө шүүхэд гаргаж буй этгээд нь уг хүсэлт, төлөвлөгөөний хуулбарыг Зохицуулах хороонд хүргүүлнэ.

77.2. Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг хэлэлцэж буй нэхэмжлэгчдийн хуралд Зохицуулах хороо оролцож саналаа илэрхийлэх эрхтэй.

77.3. Шүүх даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг Зохицуулах хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр батлахгүй.

77.4. Шүүхээс даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг батлах үйл ажиллагаанд Дампуурлын тухай хуулийн 28 дугаар зүйл үйлчлэхгүй.

78 дугаар зүйл. Даатгагчийг татан буулгах

78.1. Даатгагчийг татан буулгахтай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг

Иргэний хууль, Дампуурлын тухай хууль, Компанийн тухай хуулийн дагуу зохицуулна.

78.2. Даатгагчийг дараах тохиолдолд татан буулгана:

78.2.1. Шүүхийн шийдвэрээр;
78.2.2. Зохицуулах хорооноос бичгээр зөвшөөрсөн тохиолдолд хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр.

78.3. Даатгагчийг татан буулгах тухай хувь нийлүүлэгчдийн хурлаас гаргасан шийдвэр нь Зохицуулах хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр хүчин төгөлдөр бус байна.

78.4. Энэ хуулийн 78.2-т зааснаас бусад тохиолдолд даатгагчийг татан буулгасан шийдвэр хүчин төгөлдөр бус байна.

78.5. Дараах тохиолдолд Зохицуулах хороо даатгалын компанийг татан буулгах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргана:

78.5.1. даатгалын компани төлбөрийн чадваргүй болсон;

78.5.2. даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

78.6. Зохицуулах хороо тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан хуулийн этгээдийг татан буулгуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргаж болно.

78.7. Даатгагчийг татан буулгахаар нэхэмжлэл гаргасан тухай шүүх Зохицуулах хороонд мэдэгдэх бөгөөд Зохицуулах хороо нэхэмжлэлтэй холбоотой аливаа асуудлыг хэлэлцэхэд оролцох, тайлбар өгөх эрхтэй.

78.8. Дампуурлын тухай хуулийн дагуу даатгагчийг татан буулгахад шүүх хяналт тавих бөгөөд Дампуурлын тухай хуулийн 38.1 дэх хэсэг үйлчлэхгүй.

79 дүгээр зүйл. Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр даатгагчийг татан буулгах

79.1. Энэ хуулийн 78.2.2-т заасны дагуу гаргасан хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр даатгагчийг татан буулгах тухай өргөдөлд татан буулгах комиссын гишүүнээр томилуулахаар санал болгож буй этгээдийн нэрсийн жагсаалтыг хавсаргана.

79.2. Зохицуулах хороо хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр даатгагчийг татан буулгах зөвшөөрлийг дараах тохиолдолд олгохгүй:

79.2.1. даатгагчийн хөрөнгийн нийт үнэлгээнээс түүний хүлээсэн үүргийг хасаж үлдсэн хэсэг нь энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн доод хэмжээг хангахгүй;

79.2.2. татан буулгах комиссын гишүүнээр томилуулахаар санал болгож буй этгээд нь ийнхүү ажиллахад шаардлагатай үр чадвар, дадлага туршлагагүй.



79.3.Хувь нийлүүлэгчдийн хурлаас даатгагчийг татан буулгах тухай тогтоолыг батлахдаа татан буулгах комиссыг томилно.

79.4.Татан буулгах комисс томилогдсон тухайгаа тогтоолд заасан хугацаанд Зохицуулах хороонд мэдэгдэх үүрэгтэй.

79.5.Татан буулгах комиссын эрх хэмжээг Зохицуулах хорооноос холбогдох хуульд нийцүүлэн тогтооно.

80 дугаар зүйл. Даатгагчийн урт хугацааны сан

80.1.Урт хугацааны даатгагч нь удаан хугацаагаар тогтвортой үйл ажиллагаа эрхлэх үүднээс урт хугацааны сан бүрдүүлнэ.

80.2.Урт хугацааны даатгагч Дамлуурлын тухай хууль болон бусад хуулийн дагуу татан буугдахад даатгагчийн урт хугацааны санг зөвхөн энэ хуулийн 80 дугаар зүйлд заасны дагуу зарцуулна.

80.3.Даатгагчийн урт хугацааны сан нь тус санд хамаарах даатгагчийн урт хугацаат үүргийн гүйцэтгэлийг хангахад зарцуулагдах бөгөөд энэ хэмжээгээрээ даатгагчийн хуваарилагдах хөрөнгө гэж тооцогдохгүй.

80.4.Энэ хуулийн 80.3-т заасны дагуу зарцуулсны дараа үлдсэн хөрөнгийг Иргэний хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу даатгагчийн хуваарилагдах хөрөнгө гэж тооцож болно.

АРВАНДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад

81 дүгээр зүйл. Мэдээллийн нууцлалыг хадгалах

81.1.Зохицуулах хороо болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтан нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь этгээдтэй холбоотой аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно:

81.1.1.тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргасан этгээд;

81.1.2.даатгагч, эсхүл даатгагч байсан этгээд, тэдгээрийн хараат болон охин компани;

81.1.3.даатгуулагч, эсхүл даатгуулагч байсан этгээд.

81.2.Дараахь тохиолдолд энэ хуулийн 81.1 дэх хэсэг хамаарахгүй:

81.2.1.тухайн этгээд өөрийн нууцыг задруулахыг бичгээр зөвшөөрсөн;

81.2.2.Зохицуулах хороо шаардсан;

81.2.3.шүүх болон прокурор, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын шаардлагаар тэдгээр байгууллагын удирдлага хүсэлт гаргасан;

81.2.4.энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор тухайн этгээд мэдэх шаардлагатай;

81.2.5.уг мэдээллийг олон нийт бусад эх сурвалжаас мэдэх боломжтой, эсхүл нэгэнт мэдээлэгдсэн;

81.2.6.тухайн мэдээлэлтэй холбогдох энэ хуулийн 81.1-д заасан этгээдийг таних боломжгүй байдлаар буюу мэдээллийг товчлол, эсхүл статистик тоо баримтаар мэдээлэх;

81.2.7.энэ хуулийн 66 дугаар зүйлд заасны дагуу гадаадын зохицуулах байгууллага бичгээр хүсэлт гаргасан.

82 дугаар зүйл.Зохицуулах хорооны шийдвэрийг давж заалдах

82.1.Аливаа этгээд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг Зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд давж заалдаж болно.

82.2.Зохицуулах хорооны шийдвэрийг давж заалдсан нь хариуцлага хүлээлгэх шийдвэрийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй бөгөөд даатгагчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг шийдвэрлэхэд Захиргааны хариуцлагын тухай¹ хуулийн 19.2, 19.3 дахь хэсэг хамаарахгүй.

83 дугаар зүйл. Даатгалын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

83.1.Даатгалын тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хяналтын улсын байцаагч гэм буруутай этгээдэд дараахь хариуцлага ногдуулна:

83.1.1.тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагаа эрхэлсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.2.энэ хуулийн 17.2-т заасны дагуу Зохицуулах хорооны зөвшөөрөлгүй гадаад улсын даатгагчтай даатгалын гэрээ байгуулсан иргэнийг 10000-25000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.3.энэ хуулийн 21.1, 21.2-т заасны дагуу Зохицуулах хорооны зөвшөөрөлгүй өөрийн эзэмшиж буй хөрөнгийг бусдад шилжүүлсэн

¹ "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны №4.5

буюу өөртөө шилжүүлэн авсан, эсхүл энэ хуулийн 21.3-ыг зөрчсөн бол 50000-100000 төгрөгөөр торгох;
83.1.4.энэ хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу дүрмийн сангийн доод хэмжээг бүрдүүлээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.5.энэ хуулийн 23.1-д заасны дагуу даатгагчаас гаргаж буй хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр гүйцэтгэсэн бол 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.6.энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг дагаж мөрдөөгүй бол даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.7.энэ хуулийн 25.2-т заасны дагуу нөөц сэнг бүрдүүлээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.8.энэ хуулийн 26 дугаар зүйлд заасныг зөрчиж ногдол ашиг хуваарилсан, эсхүл хуваарилахаар зарласан даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.9.энэ хуулийн 27 дугаар зүйлд заасныг зөрчсөн албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.10.энэ хуулийн 29.2, 29.6, 67.1.8-д заасныг зөрчиж нягтлан бодох болон санхүүгийн бүртгэлээ зохих ёсоор хөтлөөгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.11.энэ хуулийн 33.2-т заасны зөрчиж аудиторыг томилсон бол албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.12.энэ хуулийн 36.1, 36.2-т заасан үүргээ биелүүлээгүй аудиторыг 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.13.энэ хуулийн 38.1, 42.3-т заасны дагуу Зохицуулах хорооноос тавьсан шаардлагыг биелүүлээгүй албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, даатгагчийг 500000-100000 төгрөгөөр торгох;

83.1.14.энэ хуулийн 39.1-д заасныг зөрчиж актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй этгээд актуарчаар ажилласан бол хууль бусаар олсон орлогыг хурааж 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.15.энэ хуулийн 40 дугаар зүйлд заасны дагуу өөрийн актуарчийг томилсоогүй, эсхүл энэ хуулийн 42.1-д заасны дагуу актуарын хяналт шалгалт хийлгээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.16.энэ хуулийн 41, 44 дүгээр зүйлд заасан үүргээ биелүүлээгүй актуарчийг 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.17.энэ хуулийн 47.1, 50 дугаар зүйлд заасны дагуу давхар даатгалын болон бизнес төлөвлөгөөг батлуулаагүй, эсхүл эдгээр төлөвлөгөөг дагаж мөрдөх үүргээ биелүүлээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.18.энэ хуулийн 48.1-д заасны дагуу давхар даатгалын төлөвлөгөөний нарийвчилсан тайланг гаргаж өгөөгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.19.энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасныг зөрчиж даатгалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоогүй үйл ажиллагаа эрхэлсэн даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.20.энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасныг зөрчсөн даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.21.энэ хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу даатгагчийн оршин байгаа газрын хаяг болон түүний өөрчлөлтийг мэдэгдээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.22.энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасан салбар, төлөөлөгчийн газар нээхтэй холбогдсон журмыг зөрчсөн даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.23.энэ хуулийн 55.1-д заасныг зөрчиж Зохицуулах хорооны зөвшөөрөлгүйгээр эрх бүхий албан тушаалтныг томилсон бол албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.24.энэ хуулийн 60 дугаар зүйлд заасан нэр ашиглах журмыг зөрчсөн даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.25.энэ хуулийн 63 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй холбогдох этгээдийг 500000-1000000 төгрөгөөр, албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.26.энэ хуулийн 64.3-т заасан үүргээ биелүүлээгүй холбогдох этгээдийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.27.энэ хуулийн 65.6-т заасан мэдэгдлийг биелүүлээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.28.энэ хуулийн 71.1-д заасныг зөрчиж шинээр даатгалын гэрээ байгуулсан, даатгалын гэрээнд өөрчлөлт оруулсан даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.29.энэ хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу Зохицуулах хорооноос өгсөн



даалгаврыг биелүүлээгүй албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.30.энэ хуулийн 75.1-д заасныг зөрчиж Зохицуулах хорооноос зөвшөөрөл авалгүйгээр даатгалын үйл ажиллагааг шилжүүлсэн, нэгтгэсэн даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.31.энэ хуулийн 22.4, 24.4, 25.4, 40.2, 55.3, 57 дугаар зүйлд заасны дагуу Зохицуулах хороонд мэдэгдээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.32.даатгалын тухай хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар Зохицуулах хорооны гаргасан шийдвэрийг биелүүлээгүй ажилтан, албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.33 хуулиар тогтоосон заавал даатгалд даатгуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-150000 төгрөгөөр, иргэнийг 5000-20000 төгрөгөөр торгох.

84 дүгээр зүйл. Зохицуулах хорооны албан хаагчийн хязгаарлагдмал хариуцлага

84.1.Зохицуулах хорооны албан хаагч энэ хууль, холбогдох бусад хууль болон даатгалын багц дүрэмд заасан үүргээ шударга бусаар хэрэгжүүлсэн буюу санаатайгаар хэрэгжүүлээгүй болох нь тогтоогдсоноос бусад тохиолдолд хариуцлага хүлээхгүй.

85 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

85.1.Энэ хуулийг 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

85.2.Энэ хуулийн даатгалын компанийн дүрмийн сангийн хэмжээг заасан 22.1 дэх хэсгийг 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлж, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд хяналт тавих, тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль тогтоомж

2.1.Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль¹, Иргэний

хууль², Компанийн тухай хууль³, Даатгалын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаатай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Даатгалын тухай хуулийн дагуу зохицуулна.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн энэ хуулийн 3.2-т зааснаас бусад нэр томъёог Даатгалын тухай хуульд заасан утгаар ойлгоно.

3.2.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

¹ "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны №1

² "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны №7

³ "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны № 34

3.2.1. "даатгалын мэргэжлийн оролцогч" гэж даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийг;

3.2.2. "даатгалын төлөөлөгч" гэж даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий даатгагчийн томилсон буюу эрх олгосон этгээдийг;

3.2.3. "даатгалын зуучлагч" гэж даатгагч болон даатгуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх, үүнийхээ төлөө хөлс, шагнал авах эрх бүхий этгээдийг;

3.2.4. "даатгалын хохирол үнэлэгч" гэж даатгагч болон даатгуулагчийн нэрийн өмнөөс даатгалын гэрээтэй холбоотой нэхэмжлэлийг хянан шалгах, бодит хохирлыг тогтоох, талуудын хооронд хэлэлцээ хийх чиг үүргийг бие даан хэрэгжүүлэх, ийнхүү хэрэгжүүлсний төлөө цалин хөлс болон бусад төлбөр авах эрх бүхий этгээдийг;

3.2.5. "Зохицуулах хороо" гэж Даатгалын тухай хуулийн 12.1-д заасан байгууллагыг;

3.2.6. "гадаадын мэргэжлийн оролцогч" гэж гадаад улсад үүсгэн байгуулагдаж, үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж буй даатгалын төлөөлөгч, зуучлагч, хохирол үнэлэгчийг.

3.3. Даатгагчаас цалинжин ажиллаж буй ажилтан энэ хуулийн 3.2.2-т заасан даатгалын төлөөлөгчид хамаарахгүй.

3.4. Дараахь этгээдийг энэ хуулийн 3.2.4-т заасан даатгалын хохирол үнэлэгч гэж тооцохгүй:

3.4.1. даатгагчийн буюу даатгалын төлөөлөгчийн ажилтан;

3.4.2. даатгалын төлөөлөгч.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг төрөөс зохицуулах

4 дүгээр зүйл. Даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

4.1. Даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1. даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;

4.1.2. хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

5 дугаар зүйл. Зохицуулах хороо

5.1. Зохицуулах хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд хяналт тавих;

5.1.2. даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

5.1.3. даатгалын мэргэжлийн оролцогчийн тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан этгээдэд арга хэмжээ авах;

5.1.4. даатгалын багц дүрмийг батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

5.1.5. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

6 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг зохицуулах багц дүрэм

6.1. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг Зохицуулах хорооноос баталсан даатгалын багц дүрмээр зохицуулна.

6.2. Даатгалын багц дүрэмд Даатгалын тухай хуулийн 14.2-т зааснаас гадна дараахь дүрэм, журам, заавар, нөхцөл, шаардлага, хэмжээ багтана:

6.2.1. даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага;

6.2.2. даатгалын мэргэжлийн оролцогчийн аудиторт тавигдах шаардлага;

6.2.3. даатгалын мэргэжлийн оролцогчийн нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг, санхүүгийн тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам;

6.2.4. энэ хуульд заасан тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт;



6.2.5. Зохицуулах хороонд төлөх төлбөр, хураамжийн хэмжээ;

6.2.6. гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх болон гадаадад үйл ажиллагаа явуулах даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага;

6.2.7. Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан үйл ажиллагаа явуулах гадаадын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлага;

6.2.8. даатгалын мэргэжлийн оролцогчоос энэ хуульд заасны дагуу тайлан, мэдээ гаргах заавар.

7 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн бизнесийн үйл ажиллагааны журам

7.1. Зохицуулах хороо даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг зохистой явуулах зорилгоор тусгайлан журам гаргаж болно.

7.2. Даатгалын мэргэжлийн оролцогч энэ хуулийн 7.1-д заасан журмыг заввал дагаж мөрдөх үүрэг хүлээхгүй боловч ийнхүү дагаж мөрдөөгүй нь түүнд хариуцлага ногдуулахад түүнийг даатгалын мэргэжлийн оролцогчийн тусгай зөвшөөрлийг эзэмших тохиромжтой бус этгээд, эсхүл үйл ажиллагаагаа зохистой явуулаагүй гэж үзэх нөхцөл болж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох

8 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн төрөл

8.1. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нь дараахь төрөлтэй байна.

8.1.1. даатгалын төлөөлөгчийн;

8.1.2. даатгалын зуучлагчийн;

8.1.3. даатгалын хохирол үнэлэгчийн.

9 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглох

9.1. Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлгүйгээр аливаа этгээд Монгол Улсад болон Монгол Улсаас гадаад улсын нутаг дэвсгэрт

даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

9.2. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд гадаад улсын нутаг дэвсгэрт даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бол энэ хуулийн 9.1-д заасны дагуу Монгол Улсаас гадаад улсын нутаг дэвсгэрт даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулсанд тооцно.

9.3. Энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон даатгалын мэргэжлийн оролцогч энэ хуулийн 9.1-д заасанчлан даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах эрхгүй.

9.4. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай¹ хуулиар зохицуулна.

10 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл хүсэх тухай өргөдөл гаргах

10.1. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн этгээд Зохицуулах хороонд өргөдөл гаргана.

10.2. Өргөдлийг бичгээр гаргах бөгөөд түүнд эрхлэх үйл ажиллагааны төрлийг зааж, Зохицуулах хорооноос тогтоосон загварын дагуу энэ хууль болон даатгалын багц дүрэмд заасан баримт бичгийг хавсаргаж ирүүлнэ.

10.3. Даатгалын зуучлагч болон даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл хүссэн этгээд нь эрхлэх үйл ажиллагаандаа хамаарах даатгалын төрөл, хэлбэрийг өргөдөлд заана.

10.4. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн этгээд даатгалчийн зөвшөөрлийг өргөдөлд хавсаргана.

10.5. Зохицуулах хороо шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээлэл, баримт бичгийг өргөдөл гаргагчаас шаардаж болно.

11 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах

11.1. Зохицуулах хороо дараахь шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид тусгай зөвшөөрлийг олгох бөгөөд тухайн төрөл, хэлбэрээс хамааран нэмэлт шаардлага тавьж болно:

¹ "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны №6



11.1.1. тусгай зөвшөөрөл олгосон нь энэ хуулийн 12 дугаар зүйлийг зөрчихөөргүй бол;

11.1.2. өргөдөл гаргагч нь даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээд бол;

11.1.3. өргөдөл гаргагч нь хуулийн этгээд бол түүний эрх бүхий албан тушаалтан, компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшдэг этгээд тус тус тохиромжтой этгээд бол;

11.1.4. өргөдөл гаргагч энэ хууль болон даатгалын багц дүрмийг дагаж мөрдөх бүрэн боломжтой гэдэг нь нотлогдож байна гэж үзвэл;

11.1.5. тухайн төрлийн даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэхэд өргөдөл гаргагчийн удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн эх үүсвэр хангалттай гэж үзвэл;

11.1.6. өргөдөл гаргагчийн нэр нь өргөдөл гаргагч даатгалын үйл ажиллагаа эрхлэх, эсхүл даатгалын зуучлагчийн тухайн үйл ажиллагааг эрхэлнэ гэдгийг илэрхийлэхгүй бол;

11.1.7. тусгай зөвшөөрөл олгох нь нийтийн болон даатгуулагчийн ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж үзвэл.

11.2. Зохицуулах хороо даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны цар хүрээ, тусгай зөвшөөрлийн төрөл, хэлбэрээс хамааран тусгай зөвшөөрөлд тавигдах нөхцөл, шаардлагыг хэдийд ч өөрчлөн тогтоож болно.

11.3. Тусгай зөвшөөрлийг бичгээр олгох бөгөөд түүнд дараахь зүйлийг тусгана:

11.3.1. тусгай зөвшөөрлийг олгосон байгууллагын нэр;

11.3.2. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр хаяг;

11.3.3. эрхлэх үйл ажиллагааны төрөл;

11.3.4. даатгалын зуучлагч, хохирол үнэлэгчийн хувьд эрхлэх даатгалын үйл ажиллагааны төрөл, хэлбэр;

11.3.5. даатгалын төлөөлөгчийн хувьд даатгагчийн зөвшөөрөл;

11.3.6. эрхлэх үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага;

11.3.7. тусгай зөвшөөрлийн дугаар, олгосон огноо;

11.3.8. тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга/гэмдэг/.

11.4. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгох бөгөөд уг зөвшөөрөл нь энэ хуулийн 38, 39 дүгээр зүйлд заасны дагуу түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл хүчин төгөлдөр байна.

11.5. Зохицуулах хороо өргөдөл гаргагчид тусгай зөвшөөрөл олгохоос татгалзан, эсхүл тусгай зөвшөөрөл олгохыг зөвшөөрсөн боловч даатгалын мэргэжлийн оролцогчийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөөгүй бол энэ тухай бичгээр мэдэгдэж, татгалзсан үндэслэлийг заана.

11.6. Зохицуулах хороо өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 45 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

11.7. Зохицуулах хороо тусгай зөвшөөрөл олгосон тухай даатгалын багц дүрэмд заасны дагуу нийгэд мэдээлнэ.

11.8. Зохицуулах хороо энэ хуулийн 11.1-д заасан "төхиромжтой этгээд"-ийг тодорхойлох зааврыг гаргаж болно.

12 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих хязгаарлалт

12.1. Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг зөвхөн компанид олгоно.

12.2. Даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөлтэй компанийн ажилтан, эрх бүхий албан тушаалтан болон компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээдэд даатгалын төлөөлөгч болон даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохгүй.

12.3. Даатгагчид даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрлийг олгохгүй.

12.4. Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээдэд даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохгүй бөгөөд уг этгээд нь даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ажилтан буюу эрх бүхий албан тушаалтан байж болохгүй.

12.5. Даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг давхардуулан олгохгүй.

12.6. Даатгалын хохирол үнэлэгчид даатгалын зуучлагч болон даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохгүй.

13 дугаар зүйл. Гадаадын мэргэжлийн оролцогч

13.1. Гадаадын мэргэжлийн оролцогч нь гагцхүү Зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах эрхтэй.

13.2. Гадаадын мэргэжлийн оролцогч нь энэ хуулийн 13.1-д заасны дагуу Зохицуулах хорооноос бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд аливаа этгээд гадаадын мэргэжлийн оролцогчийг төлөөлж дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

13.2.1. мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах зорилгоор сурталчилгаа, ухуулга хийх, эсхүл ийм зорилгоор албан газар нээх, ажиллуулах;

13.2.2. салбар, төлөөлөгчийн газар нээх, ажиллуулах.

13.3. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг хүсч буй этгээд нь Зохицуулах хороонд өргөдөл гаргана.

13.4. Өргөдлийг бичгээр гаргах бөгөөд түүнд холбогдох журамд заасан баримт бичгийг хавсаргана.

13.5. Зохицуулах хороо энэ хуулийн 13.1-д заасан зөвшөөрлийг хүссэн өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэхдээ нэмэлт мэдээлэл, баримт бичгийг өргөдөл гаргагчаас шаардаж болно.

13.6. Энэ хуулийн 13.1-д заасан зөвшөөрөл олгохдоо Зохицуулах хороо тодорхой нөхцөл, шаардлага тавьж болох бөгөөд эдгээр нөхцөл, шаардлагаа хэдийд ч өөрчлөн тогтоож болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хөрөнгө, хувьцаа

14 дүгээр зүйл. Дүрмийн сангийн доод хэмжээ

14.1. Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн дүрмийн сан нь мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд дараахь хэмжээтэй байна:

14.1.1. даатгалын багц дүрэмд заасан хэмжээнээс багагүй;

14.1.2. энэ хуулийн 14.2-т заасны дагуу Зохицуулах хорооноос тогтоосон хэмжээнээс багагүй.

14.2. Зохицуулах хороо тухайн даатгалын зуучлагч болон даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээгээс хамааран дүрмийн сангийн доод хэмжээг энэ хуулийн 14.1-д заасан хэмжээнээс дээгүүр тогтоож болно.

14.3. Энэ хуулийн 14.2-т заасан дүрмийн сангийн доод хэмжээнд хүрэх боломжит хугацааг даатгалын мэргэжлийн оролцогчид олгоно.

14.4. Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн дүрмийн сан энэ хуулийн 14.1-д заасан хэмжээнд хүрэхгүй болсон тохиолдолд энэ тухай Зохицуулах хороонд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

15 дугаар зүйл. Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн хувьцаа

15.1. Энэ хуулийг дагаж мөрдсөн өдрөөс хойш даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн гаргаж буй бүх хувьцааны төлбөрийг мөнгөн хэлбэрээр хийнэ.

15.2. Даатгалын зуучлагч болон даатгалын хохирол үнэлэгчид Компанийн тухай хуулийн 45 дугаар зүйл хамаарахгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ

Нягтлан бодох бүртгэл, аудит

16 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлт болон санхүүгийн тайлан

16.1. Даатгалын мэргэжлийн оролцогч Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль⁶ болон даатгалын багц дүрэмд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.

16.2. Даатгалын мэргэжлийн оролцогч нягтлан бодох бүртгэлээ акрүэл сууриар хөтлөх

⁶ "Төрийн мэдээлэл" амхтгэлийн 2002 оны №4

бөгөөд даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.2 дахь хэсэг хамаарахгүй.

16.3. Даатгалын багц дүрэмд өөрөөр заагаагүй бол Зохицуулах хороо даатгалын мэргэжлийн оролцогчийн нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг, санхүүгийн тайлангийн агуулга, хэлбэрийг тогтоож болно.

16.4. Даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.2 болон даатгалын багц дүрэмд заасан, эсхүл энэ хуулийн 16.3-т заасан Зохицуулах хорооноос тогтоосон бусад баримт бичгээс бүрдэнэ.

16.5. Даатгалын мэргэжлийн оролцогч нь нягтлан бодох бүртгэлийн баримт бичгээ 6 жилээс доошгүй хугацаагаар хадгалах бөгөөд хадгалах газрын хаягийг Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэнэ.

17 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн стандарт хэрэглэх

17.1. Даатгалын мэргэжлийн оролцогч нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мөрдөнө.

18 дугаар зүйл. Жил бүрийн санхүүгийн тайлан

18.1. Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч нь аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд дараахь баримт бичгийн хамт Зохицуулах хороонд тушаана:

18.1.1. удирдлагын тайлан;

18.1.2. аудитын дүгнэлт;

18.1.3. тухайн санхүүгийн жилд компанийн үйл ажиллагаанд нөлөөлсөн үйл явдлын тухай тодруулга, тайлбар;

18.1.4. багц дүрэмд заасан бусад баримт бичиг.

18.2. Жил бүрийн санхүүгийн тайлан болон бусад баримт бичгийн агуулга, хэлбэрийг даатгалын багц дүрмээр тогтоож болно.

18.3. Энэ хуулийн 18.1-д заасан тайлан болон бусад баримт бичгийг Зохицуулах хороонд ирүүлээгүй тохиолдолд санхүүгийн тайланг өгөөгүйд тооцно.

19 дүгээр зүйл. Улирал тутмын санхүүгийн тайлан

19.1. Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч нь улирал тутмын санхүүгийн тайлангаа даатгалын багц дүрэмд заасан баримт бичгийн хамт Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Зохицуулах хороонд тушаана.

19.2. Улирал тутмын санхүүгийн тайлан, холбогдох бусад баримт бичгийн агуулга, хэлбэрийг даатгалын багц дүрмээр тогтоож болно.

19.3. Энэ хуулийн 19.1-д заасан тайлан болон бусад баримт бичгийг Зохицуулах хороонд ирүүлээгүй тохиолдолд тайланг өгөөгүйд тооцно.

20 дугаар зүйл. Аудит

20.1. Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч санхүүгийн тайлангаа баталгаажуулах зорилгоор аудиторыг томилно.

20.2. Энэ хуулийн 20.1-д заасан аудитор нь дараахь шаардлагыг хангасан байна:

20.2.1. Аудитын тухай⁶ хуулийн 17 дугаар зүйлд заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй;

20.2.2. даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн санхүүгийн тайланг баталгаажуулах эрхийг Зохицуулах хорооноос авсан.

20.3. Зохицуулах хороо энэ хуулийн 20.2-т заасан аудиторын нэрсийн жагсаалт болон түүний өөрчлөлтийг даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

20.4. Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч нь аудиторыг аудитын үйл ажиллагаа явуулах нөхцөл, боломжоор хангана.

20.5. Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч аудиторыг томилсноос хойш ажлын 5 хоногийн дотор Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэнэ.

21 дүгээр зүйл. Аудитын тайлан

21.1. Аудитор нь санхүүгийн тайлангийн талаархи дүгнэлтийг даатгалын багц дүрэмд заасны дагуу даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчид хүргүүлнэ.

21.2. Зохицуулах хороо эд хөрөнгийн чанар, эрсдлийн сангийн зохистой харьцаа, нягтлан бодох бүртгэл болон хяналтын тогтолцооны зохистой

⁶ "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1997 оны №6

харьцааг тодорхойлох зорилгоор аудитын тайлан гаргаж өгөхийг даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчээс хэдийд ч шаардаж болно.

21.3.Энэ хуулийн 21.2-т заасан тайлан бэлтгэхтэй холбогдсон зардлыг даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч хариуцна.

22 дугаар зүйл. Аудиторын үүрэг

22.1 Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн баримт материалд үндэслэн гаргасан дараахь дүгнэлтийн талаар аудитор нь Зохицуулах хороонд нэн даруй мэдэгдэнэ:

22.1.1 даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч төлбөрийн чадваргүй болсон буюу төлбөрийн чадваргүй болж болзошгүй байгаа;

22.1.2 эрхэлж буй үйл ажиллагаатай холбоотой гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдсэн байж болзошгүй;

22.1.3 энэ хуулийн 14, 15 дугаар зүйлийг зөрчсөн;

22.1.4 энэ хууль, бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрмийг ноцтойгоор зөрчсөн гэж үзсэн.

22.2 Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч нь аудитортой байгуулсан гэрээгээ цуцалсан, эсхүл ажиллах боломжгүй гэдгээ мэдэгдэж чөлөөлөгдсөн тохиолдолд аудитор Зохицуулах хороонд дараахь асуудлаар мэдээлэл өгнө:

22.2.1 гэрээг цуцалсан буюу чөлөөлөгдсөн тухай, түүний үндэслэлийн талаар;

22.2.2 энэ хуулийн 21, 22.1-д заасан тайлан болон мэдээллийн талаар.

22.3 Зохицуулах хороо аудитороос аудитын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, нэмэлт материал шаардаж болно.

22.4 Аудитор болон аудитор байсан этгээд энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан тайлан болон өөрийн зөв гэж үзсэн бусад мэдээллээр Зохицуулах хороог хангасны төлөө түүнийг мэргэжлийн ёс зүйн дүрэм болон хууль тогтоомж

зөрчсөн гэж үзэхгүй бөгөөд түүнд эрүүгийн болон бусад хариуцлага ногдуулахгүй.

23 дугаар зүйл. Зохицуулах хорооноос аудиторыг томилох

23.1 Хэрэв даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч энэ хуулийн 20.1-д заасны дагуу аудиторыг томилоогүй бол Зохицуулах хороо аудиторыг томилж болно.

23.2 Энэ хуулийн 23.1-д заасан аудитор нь даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн аудиторын энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Даатгалын мэргэжлийн оролцогчид тавих хязгаарлалт

24 дүгээр зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогч, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтанд тавих хязгаарлалт

24.1 Даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөлтэй этгээдийн эрх бүхий албан тушаалтан, ажилтныг даатгагчийн захирлаар томилж болохгүй.

24.2 Даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрөлтэй этгээдийг даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөлтэй этгээдийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнаар томилж болохгүй.

25 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлгүй даатгагч

25.1 Даатгалын мэргэжлийн оролцогч Даатгалын тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл аваагүй даатгагчтай хамтран үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

25.2 Энэ хуулийн 25.1 дэх хэсэг даатгалын мэргэжлийн оролцогч гадаадын даатгагчтай хамтран ажиллахад хамаарахгүй.

26 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн төлбөр, хөлс, хураамж

26.1 Даатгалын мэргэжлийн оролцогч дор дурдсанаас бусад тохиолдолд даатгагчийн байгуулсан гэрээний дагуу төлөгдөж буй

хураамжийг хүлээн авах, эзэмших, түүнтэй холбоотой хэлцэл хийхийг хориглоно:

26.1.1 даатгалын хураамжийг хүлээн авах, эзэмших, түүнтэй холбоотой хэлцэл хийхийг даатгагч зөвшөөрсөн;

26.1.2 Зохицуулах хорооноос эрх олгосон.

27 дугаар зүйл. Мэдээллийг өөрчлөх

27.1 Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэж байгаа этгээд, эсхүл даатгалын мэргэжлийн оролцогч болон бусад этгээдээс энэ хууль, даатгалын багц дүрэмд заасны дагуу Зохицуулах хороонд гаргаж буй зөвшөөрөл хүссэн өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэхээс өмнө Зохицуулах хороонд ирүүлсэн мэдээлэл, баримтад өөрчлөлт орвол зөвшөөрөл хүссэн этгээд энэ тухай нэн даруй бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Зах зээлийн ёс зүй

28 дугаар зүйл. Төөрөгдүүлсэн зэр сурталчилгаа

28.1 Даатгалын мэргэжлийн оролцогч нь төөрөгдүүлсэн, эсхүл худал мэдээлэл агуулсан зэр сурталчилгаа, мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад бичиг баримт гаргах, тараах, тараахыг зөвшөөрөхийг хориглоно.

28.2 Даатгалын мэргэжлийн оролцогч болон түүний нэрийн өмнөөс гаргасан мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг нь төөрөгдүүлсэн буюу худал мэдээлэл агуулсан, эсхүл нийтийн ашиг сонирхолд харшилсан гэж үзвэл Зохицуулах хороо тухайн баримт бичгийг гаргахыг хориглох, няцаахыг даалгах, эсхүл шаардлагатай гэж үзсэн өөрчлөлт, залруулга хийж гаргахыг бичгээр даалгана.

29 дүгээр зүйл. Зах зээлийн ёс зүй

29.1 Зохицуулах хороо даатгалын мэргэжлийн оролцогчийн дагаж мөрдвөл зохих зах зээлийн ёс зүйн журам гаргаж болох бөгөөд даатгалын мэргэжлийн оролцогч, түүний эрх бүхий албан тушаалтан болон холбогдох бусад этгээд түүнийг дагаж мөрдөх үүрэгтэй.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Хяналт шалгалт, мэдээлэл цуглуулах, тайлагнах

30 дугаар зүйл. Үйл ажиллагааны шалгалтад хамаарах холбогдох этгээд

30.1 Энэ хуулийн наймдугаар бүлэгт заасан "холбогдох этгээд" гэдэгт даатгалын мэргэжлийн оролцогч, даатгалын мэргэжлийн оролцогч байсан этгээд, эсхүл тэдгээрийн хараат болон охин компани хамаарна.

31 дүгээр зүйл. Холбогдох этгээдийн үйл ажиллагаанд хийх шалгалт

31.1 Зохицуулах хороо холбогдох этгээдийн үйл ажиллагааг энэ хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд шалгах зорилгоор дараахь арга хэмжээг хэдийд ч авч хэрэгжүүлж болно:

31.1.1 холбогдох этгээдийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, баримт бичгийг шалгах;

31.1.2 холбогдох этгээдийн хяналт болон эзэмшилд буй эд хөрөнгө, бэлэн мөнгө зэргийг шалгах, тоолох;

31.1.3 холбогдох этгээдийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон бусад баримт бичгийг хуулбарлаж авах, хянан шалгах.

31.2 Зохицуулах хороо шаардлагатай гэж үзвэл холбогдох этгээдэд хяналт тавихтай холбоотой дараахь асуудлыг судлан үзэж болно:

31.2.1 холбогдох этгээдийн эд хөрөнгийг шалгах;

31.2.2 энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрэм болон Зохицуулах хорооноос тавьсан шаардлага, үүрэг даалгаврыг биелүүлж байгаа эсэх.

31.3 Зохицуулах хороо үйл ажиллагааны шалгалтын удирдамжийг холбогдох этгээдэд урьдчилан танилцуулна.

31.4 Зохицуулах хороо шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагааны шалгалтыг хэрэгжүүлэхдээ тохирох дадлага туршлага, мэргэжил бүхий этгээдийг татан оролцуулж болно.

31.5 Үйл ажиллагааны шалгалтыг хоёр жилд нэгээс доошгүй удаа холбогдох этгээдийн өдөр тутмын үйл ажиллагаанд саад болохгүйгээр зохион байгуулна.

32 дугаар зүйл. Үйл ажиллагааны шалгалттай холбоотой холбогдох этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтны үүрэг

32.1.Холбогдох этгээд үйл ажиллагааны шалгалтын үед дараахь үүрэг хүлээнэ:

32.1.1.өөрийн байранд нэвтрэх, эд хөрөнгийг шалгах боломжоор хангах;

32.1.2.нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон холбогдох бусад баримт бичгийг гаргаж өгөх;

32.1.3.шаардлагатай мэдээлэл, тайлбараар хангах;

32.1.4.шаардлагатай баримт бичгийг бусад этгээдээс олж авч Зохицуулах хороонд өгөх.

32.2.Зохицуулах хороо шаардлагатай мэдээлэл, тайлбар гаргаж өгөхийг холбогдох этгээдийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнаас шаардаж болно.

33 дугаар зүйл. Шалгалтын тайлан

33.1.Зохицуулах хороо үйл ажиллагааны шалгалт дууссанаас хойш ажлын 45 хоногийн дотор шалгалтын товч тайланг холбогдох этгээдэд хүргүүлнэ.

33.2.Шалгалтын тайланд дараахь зүйлийг тусгана:

33.2.1.холбогдох этгээдийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хяналт болон шаардлагатай гэж үзсэн бусад асуудлын талаархи зөвлөмж;

33.2.2.тайлантай холбогдуулан хариу шаардаж байгаа эсэх, хариу шаардаагүй бол тайланд онцгойлон үзсэн асуудлын талаар.

33.3.Шалгалтын тайлантай холбогдуулан хариу шаардсан бол холбогдох этгээд тайланг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор, эсхүл тайланд тусгайлан заасан хугацаанд Зохицуулах хороонд хариу мэдэгдэх үүрэгтэй.

34 дүгээр зүйл. Зохицуулах хорооны мэдээлэл цуглуулах эрх

34.1.Зохицуулах хороо энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор, эсхүл гадаадын зохицуулах байгууллагын тавьсан хүсэлтийн дагуу энэ хуулийн 34.2-т заасан этгээдээс дараахь зүйлийг бичгээр шаардаж болно:

34.1.1.тодорхой төрлийн буюу тусгайлан заасан мэдээлэл гаргаж өгөхийг;

34.1.2.тодорхой төрлийн буюу тусгайлан заасан баримт бичиг гаргаж өгөхийг.

34.2.Энэ хуулийн 34.1-д заасан мэдэгдлийг холбогдох этгээд болон түүнтэй холбоотой этгээд, даатгалын мэргэжлийн оролцогч эсхүл, мэдэгдэлтэй холбоотой мэдээлэл, баримт бичиг байгаа гэж үзсэн этгээдэд өгөх бөгөөд уг мэдэгдэлд мэдээлэл, баримт бичгийг гаргаж өгөх болон үйлдэх хугацаа, газрыг заана.

34.3.Энэ хуулийн 34.2-т заасан "холбоотой этгээд"-ийг даатгалын багц дүрмээр тодорхойлно.

34.4.Зохицуулах хороо энэ хуулийн 34.1-д заасан эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь шаардлагыг тавьж болно:

34.4.1.тогтоосон хэлбэр, загвараар мэдээлэл бэлтгэж ирүүлэхийг;

34.4.2.мэдээлэл, баримт бичгээ баталгаажуулахыг;

34.4.3.мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан тайлбар гаргахыг.

34.5.Зохицуулах хороо энэ хуульд заасны дагуу мэдээлэл цуглуулахдаа холбогдох баримт бичгийг түүвэрлэн буюу хуулбарлан авч болно.

34.6.Зохицуулах хорооноос энэ хуулийн 34.1-д заасны дагуу мэдээлэл, баримт бичгээр хангахыг даалгасан мэдэгдлийг хүлээн авсан этгээд уг мэдэгдлийг заавал биелүүлэх үүрэгтэй.

35 дугаар зүйл. Гадаадын зохицуулах байгууллагад туслалцаа үзүүлэх

35.1.Гадаадын зохицуулах байгууллага өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан туслалцаа үзүүлэхийг бичгээр хүссэн тохиолдолд Зохицуулах хороо энэ хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу холбогдох мэдээлэл, баримт бичгээр хангаж болно.

35.2.Гадаадын зохицуулах байгууллагыг мэдээлэл, баримт бичгээр хангах эсэхийг шийдвэрлэхдээ дараахь асуудлыг анхаарна:

35.2.1.гадаадын зохицуулах байгууллага нь уг асуудалтай төстэй асуудлаар харилцан туслалцаа үзүүлж байсан, эсхүл үзүүлэх эсэх;

35.2.2.Монгол Улсын хууль тогтоомж, нийтийн ашиг сонирхолд нийцэж байгаа эсэх;

35.2.3.асуудлын шинж чанар, тухайн асуудал Монгол Улсын хувьд ач холбогдолтой эсэх;



35.2.4 мэдээлэл бэлтгэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг гадаадын зохицуулах байгууллага төлсөн эсэх;

35.2.5.энэ хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу мэдээллийн нууцлалыг хангаж чадах эсэх.

35.3.Зохицуулах хороо гадаадын зохицуулах байгууллагын хүссэн мэдээлэлтэй холбогдуулж тодруулга ирүүлэхийг уг байгууллагаас хүсэж болно.

35.4.Гадаадын зохицуулах байгууллага нь энэ хуулийн 35.3-т заасан хүсэлтэд хариу ирүүлээгүй бол Зохицуулах хороо түүнд туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Албадлага

36 дугаар зүйл. Албадлагын арга хэмжээ авах үндэслэл

36.1.Зохицуулах хороо дараахь үндэслэлээр даатгалын мэргэжлийн оролцогчид албадлагын арга хэмжээ авч болно:

36.1.1.энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрмийг зөрчсөн;

36.1.2.үйлчлүүлэгчийн болон нийтийн ашиг сонирхолд, даатгалын төлөөлөгчийн хувьд даатгагчийн ашиг сонирхолд хохирол учруулахуйц нөхцөл байдал үүссэн;

36.1.3.даатгалын мэргэжлийн оролцогч төлбөрийн чадваргүй болсон буюу төлбөрийн чадваргүй болж болзошгүй гэж үзвэл;

36.1.4.энэ хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу Зохицуулах хорооноос өгсөн даалгаврыг биелүүлээгүй;

36.1.5.тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн, тусгай зөвшөөрлийг хуурамч баримт бичиг бүрдүүлэн авсан нь тогтоогдсон;

36.1.6.тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний удирдах албан тушаалтан, компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээд нь тус тус тохиромжтой бус этгээд гэж үзсэн;

36.1.7.Зохицуулах хороонд бодитой бус, төөрөгдүүлсэн мэдээлэл өгсөн нь тогтоогдсон;

36.1.8.даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч татан буугдсан;

36.1.9.нягтлан бодох бүртгэл,

санхүүгийн тайлангаа зохих ёсоор хөтлөөгүй;

36.1.10.холбогдох этгээдийн үйл ажиллагааг шалгах явцад Зохицуулах хороотой хамтран ажиллахаас татгалзсан;

36.1.11.Зохицуулах хорооноос ногдуулсан торгуулийг хугацаанд нь төлөөгүй;

36.1.12.хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

37 дугаар зүйл. Албадлагын арга хэмжээний төрөл

37.1.Зохицуулах хороо энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан үндэслэлээр дараахь төрлийн албадлагын арга хэмжээг хэрэглэнэ:

37.1.1.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх;

37.1.2.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

37.1.3.энэ хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу шалгагч томилох;

37.1.4.энэ хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу даалгавар өгөх;

37.1.5.даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг зохистой явуулах талаар зөвлөх үүрэг бүхий, дадлага туршлагатай мэргэжилтэн томилох;

37.1.6.торгох.

38 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

38.1.Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг дараахь үндэслэлээр түдгэлзүүлнэ:

38.1.1.энэ хуулийн 36.1-д заасан үндэслэлийн аль нэг нь илэрсэн;

38.1.2.тусгай зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын дотор үйл ажиллагаагаа эхлээгүй, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон;

38.1.3.тусгай зөвшөөрлийн жил бүрийн төлбөрийг төлөх хугацаа өнгөрснөөс хойш 2 сарын дотор төлөөгүй.

38.2.Тусгай зөвшөөрлийг дараахь хугацаагаар түдгэлзүүлнэ:

38.2.1.Зохицуулах хорооноос тогтоосон хугацаагаар;

38.2.2.Зохицуулах хорооноос тавьсан шаардлага, өгсөн даалгаврыг биелүүлэх хүртэл.

38.3.Энэ хуулийн 38.2.1-д заасан хугацаа нь 6 сараас хэтрэхгүй.

38.4.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлснээс хойш энэ хуулийн 39.2.2-т заасан шаардлагыг 6 сарын дотор биелүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

38.5.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхээс өмнө Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэлийг заасан мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлж, хүргэсэн огноог тэмдэглэнэ.

38.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Зохицуулах хороонд бичгээр ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

38.7.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд дараахь агуулга бүхий мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлнэ:

38.7.1.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай;

38.7.2.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн үндэслэл, түдгэлзүүлж эхэлсэн огноо;

38.7.3.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаа.

38.8.Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээнэ.

39 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

39.1.Зохицуулах хороо дараахь үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

39.1.1.тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

39.1.2.даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч татан буугдсан;

39.1.3.тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

39.1.4.тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

39.1.5.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй.

39.2.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохоос өмнө Зохицуулах хороо тусгай

зөвшөөрлийг хүчингүй болгох болсон үндэслэлийг заасан мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлж, хүргэсэн огноог тэмдэглэнэ.

39.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Зохицуулах хороонд ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

39.4.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд дараахь агуулга бүхий мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлнэ:

39.4.1.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай;

39.4.2.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон үндэслэл, огноо.

39.5.Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээнэ.

40 дүгээр зүйл. Зохицуулах хороо даатгалын мэргэжлийн оролцогчийн эд хөрөнгийг хамгаалах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах

40.1.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон, эсхүл энэ хуулийн 38.1, 39.1-д заасан үндэслэл байна гэж үзвэл нийтийн болон үйлчлүүлэгч, даатгуулагчийн ашиг сонирхол, даатгалын мэргэжлийн оролцогчийн өмч хөрөнгө, үйл ажиллагааг хамгаалах зорилгоор Зохицуулах хороо шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

40.2.Зохицуулах хороо энэ хуулийн 40.1-д заасан нэхэмжлэл гаргахдаа даатгалын мэргэжлийн оролцогчид мэдэгдэх үүрэг хүлээхгүй.

40.3.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлээгүй, эсхүл хүчингүй болгоогүй бол нэхэмжлэлийг энэ хуулийн 38.5, 39.2-т заасан тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгох тухай мэдэгдлийг даатгалын мэргэжлийн оролцогчид өгөхөөс өмнө гаргаж болно.

40.4.Энэ хуулийн 40.1-д заасан нэхэмжлэлийн дагуу дараахь арга хэмжээг хэрэгжүүлж болно:

40.4.1.холбогдох этгээдийн эзэмшилд буй өмч хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах зэрэг хэлцэл хийхийг хориглосон шийдвэр гаргах;

40.4.2.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгохоос өмнө

даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг удирдан зохицуулах бүрэн эрхт төлөөлөгчийг нэн даруй томилох;

40.4.3.компанийг татан буулгахаар шүүхэд хандах;

40.4.4.даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар мэдээлэл авахаар холбогдох этгээдийг дуудан ирүүлэх.

40.5.Шүүх энэ хуулийн 40.4.2-т заасан бүрэн эрхт төлөөлөгчийг томилохдоо түүний эрх хэмжээ, цалин хөлс, шүүх болон Зохицуулах хороонд тайлан мэдээ гаргаж өгөх журмыг тогтооно.

40.6.Шүүх бүрэн эрхт төлөөлөгчийн талээр дараахь арга хэмжээг хэдийд ч авч болно:

40.6.1.эрх үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан даалгавар, зааварчилга өгөх;

40.6.2.эрх хэмжээг нь өөрчлөх;

40.6.3.бүрэн эрхийг нь дуусгавар болгох.

41 дүгээр зүйл. Даалгавар

41.1.Зохицуулах хороо даатгалын мэргэжлийн оролцогчид албадлагын арга хэмжээ авахдаа дараахь агуулга бүхий даалгаврыг өгч болно:

41.1.1.даатгалын мэргэжлийн оролцогчийн тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг түр зогсоох;

41.1.2.тодорхой төрлийн үйл ажиллагаатай холбоотой шинээр гэрээ байгуулахыг хориглох;

41.1.3.шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг энэ хууль, бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрэмд зааснаас богино хугацаанд гаргаж өгөх;

41.1.4.үйлчлүүлэгч болон даатгалын төлөөлөгчийн хувьд төлөөлж буй даатгалчийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шаардлагатай гэж үзсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

41.2.Энэ хуулийн 41.1-д заасны дагуу Зохицуулах хорооноос өгч буй аливаа даалгаврыг даатгалын мэргэжлийн оролцогч биелүүлэх үүрэгтэй.

41.3.Энэ хуулийн 41 дүгээр зүйл тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон этгээдэд нэгэн адил хамаарна.

42 дугаар зүйл. Шалгагчийг томилох

42.1.Зохицуулах хороо энэ хуулийн 36.1-д заасан үндэслэлээр албадлагын арга хэмжээ

авахдаа тухайн этгээдийн үйл ажиллагааг хянан шалгах үүрэг бүхий нэг буюу хэд хэдэн этгээдийг шалгагчаар томилж болно.

42.2.Энэ хуулийн 42.1-д заасны дагуу томилогдсон шалгагч нь дараахь асуудлыг хянан шалгаж болно:

42.2.1.тухайн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, шинж байдлыг;

42.2.2.тухайн этгээдийн үйл ажиллагааны тодорхой асуудлыг;

42.2.3.тухайн этгээдийн болон хувь нийлүүлэгчдийн хяналт

42.3.Шалгагч нь шаардлагатай гэж үзвэл тухайн этгээдийн үйл ажиллагаа болон компанийн нэгдлийн бусад гишүүдийн үйл ажиллагааг хэдийд ч шалгаж болно.

42.4.Шалгагчийн томилолтын хугацаа болон нөхцөлийг Зохицуулах хороо өөрийн үзэмжээр тогтооно.

АРАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

43 дугаар зүйл. Мэдээллийн нууцлалыг хадгалах

43.1.Зохицуулах хороо болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтан нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь этгээдтэй холбоотой аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно:

43.1.1.тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргасан этгээд;

43.1.2.даатгалын мэргэжлийн оролцогч, эсхүл даатгалын мэргэжлийн оролцогч байсан этгээд, тэдгээрийн хараат болон охин компани;

43.1.3.үйлчлүүлэгч, эсхүл үйлчлүүлэгч байсан этгээд.

43.2.Дараахь тохиолдолд энэ хуулийн 43.1 дэх хэсэг хамаарахгүй:

43.2.1.тухайн этгээд өөрийн нууцыг задруулахыг бичгээр зөвшөөрсөн;

43.2.2.Зохицуулах хороо шаардсан;

43.2.3.шүүх болон прокурор, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын шаардлагаар тэдгээр байгууллагын удирдлага хүсэлт гаргасан;

43.2.4.энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор тухайн этгээд мэдэх шаардлагатай;

43.2.5.уг мэдээллийг олон нийт бусад эх сурвалжаас мэдэх боломжтой, эсхүл нэгэнт мэдээлэгдсэн;

43.2.6.тухайн мэдээлэлтэй холбогдох энэ хуулийн 43.1-д заасан этгээдийг



таних боломжгүй байдлаар буюу мэдээллийг товчлол, эсхүл статистик тоо баримтаар мэдээлэх;

43.2.7.энэ хуулийн 35.1-д заасны дагуу гадаадын зохицуулах байгууллага бичгээр хүсэлт гаргасан.

44 дүгээр зүйл. Зохицуулах хорооны шийдвэрийг давж заалдах

44.1.Аливаа этгээд даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан мэргэааныг Зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд давж заалдаж болно.

44.2.Зохицуулах хорооны шийдвэрийг давж заалдсан нь хариуцлага хүлээлгэх шийдвэрийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй бөгөөд даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд Захиргааны хариуцлагын тухай хуулийн 19.2, 19.3 дахь хэсэг хамаарахгүй.

45 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

45.1.Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хяналтын улсын байцаагч гэм буруутай этгээдэд дараахь захиргааны хариуцлага ногдуулна:

45.1.1.тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхэлсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийг 500000-1000000 төгрөгөөр, даатгалын төлөөлөгчийг 200000-500000 төгрөгөөр торгох;

45.1.2.энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу дүрмийн сангийн доод хэмжээг бүрдүүлээгүй даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

45.1.3.энэ хуулийн 15.1-д заасны дагуу гаргаж буй хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр гүйцэтгэсэн даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

45.1.4.энэ хуулийн 16.2-т заасныг зөрчиж нягтлан бодох бүртгэлээ зохих ёсоор хөтлөөгүй даатгалын мэргэжлийн оролцогчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

45.1.5.энэ хуулийн 20.2-т заасныг зөрчиж аудиторыг томилсон албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр торгох;

45.1.6.энэ хуулийн 22.1, 22.2-т заасан үүргээ биелүүлээгүй аудиторыг 50000-

100000 төгрөгөөр торгох;

45.1.7.энэ хуулийн 25.1-д заасныг зөрчиж тусгай зөвшөөрөлгүй даатгалчтай хамтран үйл ажиллагаа явуулсан даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

45.1.8.энэ хуулийн 26 дугаар зүйлд заасныг зөрчсөн даатгалын мэргэжлийн оролцогчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

45.1.9.энэ хуулийн 32.1-д заасан үүргээ биелүүлээгүй холбогдох этгээдийг 500000-1000000 төгрөгөөр, албан тушаалтныг 50000-1000000 төгрөгөөр торгох;

45.1.10.энэ хуулийн 33.3-т заасан үүргээ биелүүлээгүй холбогдох этгээдийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

45.1.11.энэ хуулийн 34.6-д заасан мэдэгдлийг биелүүлээгүй даатгалын мэргэжлийн оролцогчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

45.1.12.энэ хуулийн 41 дүгээр зүйлд заасан даалгаврыг биелүүлээгүй албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, даатгалын мэргэжлийн оролцогчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

45.1.13.энэ хуулийн 14.4, 27 дугаар зүйлд заасны дагуу Зохицуулах хороонд мэдэгдээгүй даатгалын мэргэжлийн оролцогчийг 100000-150000 төгрөгөөр торгох;

45.1.14.даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар Зохицуулах хорооны гаргасан шийдвэрийг биелүүлээгүй ажилтан, албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, даатгалын мэргэжлийн оролцогчийг 500000-1000000 төгрөгөөр торгох.

46 дугаар зүйл. Зохицуулах хорооны албан хаагчийн хязгаарлагдмал хариуцлага

46.1.Зохицуулах хорооны албан хаагч энэ хууль, холбогдох бусад хууль болон даатгалын багц дүрэмд заасан үүргээ шударга бусаар хэрэгжүүлсэн буюу санаатайгаар хэрэгжүүлээгүй болох нь тогтоогдсоноос бусад тохиолдолд хариуцлага хүлээхгүй.

47 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

47.1.Энэ хуулийг Даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1997 оны 12 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан Даатгалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай. дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2005 оны 1

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Банкны тухай" гэсний дараа "Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай" гэж нэмсүгэй. дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2005 оны 1

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хоршооны тухай хуулийн 8.4-ийн "тогтооно" гэснийг "тогтоож, хэрэгжилтэд нь хяналт тавина" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг хавсралтаар баталсугай.

2. Бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган, тодорхой хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл боловсруулан ажиллах, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

3. Бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж,

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг батлах тухай дэмжлэг үзүүлэн ажиллахыг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо (Т.Ганди)-нд даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлогыг батлах тухай" Улсын Их Хурлын 1996 оны 22 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 2004 оны 21 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

А. Нийтлэг үндэслэл

Монгол Улс хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, эх орондоо иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийг зорин буй цөөн хүн амтай, өргөн

уудам нутагтай, хүн амын нягтрал багатай, нүүдлийн болон суурин соёл иргэншил хосолсон хөгжиж буй орон билээ.

Даяарчлагдаж буй дэлхий нийтийн хөгжлийн үйл явцад хүн амын идэвхтэй оролцоо чухал бөгөөд тэдний зүгээс хувь нэмрээ оруулахад нь тохиолдож буй бэрхшээлийг даван туулахад дэмжлэг үзүүлэх шаардлагатайг олон улсын хамтын нийгэмлэг хүлээн зөвшөөрч, Мянганы хөгжлийн зорилтоо тодорхойлон хэрэгжүүлж эхлээд байна.

Монгол Улсын хүн амын жилийн дундаж өсөлт 1986-2002 оны хооронд 2,8-аас 1,4 хувь болтлоо буурсан бөгөөд энэ бууралт цаашид хэвээр үргэлжилбэл 2025 он гэхэд 0,9 хувь болох төлөвтэй. Сүүлийн 10-аад жилд хот суурин руу чиглэсэн хүн амын дотоод шилжих хөдөлгөөн эрчимжиж, суурьшлын хэв шинжид томоохон өөрчлөлт орох боллоо.

Хүн амын өсөлтийн сааралт, насны бүтцийн өөрчлөлт, байршил, суурьшилтай холбогдон гарч буй асуудал нь энэхүү бодлогын өвөрмөц, онцлог байдлыг илтгэнэ.

Хүний эрхийг хангах, хөгжлийн үйл явцыг түргэтгэх, хүн амын амьдралын чанарын тэгш бус байдлыг арилгах нь хүн ам, хөгжлийн талаар тавигдаж буй тулгамдсан асуудал болж байна.

Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлогыг Улсын Их Хурлаас 1996 онд батлан хэрэгжүүлж ирсэн ба дэлхий нийтийн болон үндэсний хэмжээнд дэвшүүлж буй шинэ зорилт, хөгжлийн хандлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулах шаардлага урган гарсан юм.

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого нь хүн ам, хөгжлийн уялдаа холбоог хангахад тохиолдож буй бэрхшээлийг арилгах, хүн төвтэй хөгжилд хүрэх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, хүн амын бүлгүүдийн асуудлыг гэр бүлийн хүрээнд шийдвэрлэх, нийгмийн бүхий л харилцаанд жендэрийн тэгш байдлыг эрхэмлэхийг эн тэргүүнд чухалчилж байгаа болно.

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Нийгмийн дэвшил, хөгжлийн, Хөгжих эрхийн, Мянганы хөгжлийн, Бүх нийтийн боловсролын тухай Дажарын тунхаглал, Эмэгтэйчүүдийн тэгш байдал, хөгжил, энх тайвны асуудлаарх Найробын (1985),

Хүний эрхийн талаарх Венийн (1993), Хүн ам, хөгжлийн асуудлаарх Каирын (1994), Нийгмийн хөгжлийн асуудлаарх Колонгагийн (1995), Эмэгтэйчүүдийн байдлын талаарх Бээжингийн (1995) бага хурлуудын шийдвэр, Үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын Үндсэн хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан үндэсний хууль тогтоомж, бодлого, стратеги, бусад олон улсын болон үндэсний хэмжээний хүний эрх, хөгжлийн талаар тавьж буй зорилтыг хангахад чиглэгдсэн болно.

Энэхүү бодлогыг Монгол Улсын хөгжлийн болон Мянганы хөгжлийн зорилтыг дүгнэх үе шаттай уялдуулан 2015 он хүртэл дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат: 2004-2007 он;
Хоёрдугаар үе шат: 2008-2011 он;
Гуравдугаар үе шат: 2012-2015 он.

Б. Зорилго

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын зорилго нь хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн ардаа урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчинг бүрдүүлэхэд оршино.

В. Хүн амын хөгжлийг дэмжихэд баримтлах зарчим

- *Хүний хөгжлийг улс орны хөгжил, дэвшлийн төвд тавина:* Хүн байгальтайгаа зохицож, өөрийн чадавхи, нөөцөд түшиглэн эрүүл энх, үр бүтээлтэй ажиллаж, хангалуун амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- *Хүний эрхэд суурилсан хөгжлийн чиг хандлагыг баримтална:* Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний эрхийг дээдлэх, хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэмд аж төрөх боломжийг бүрдүүлнэ.
- Хүн ам, хөгжлийн асуудлаарх нийгмийн зөвшилцөл, оролцоог хангана: Хүн амын хөгжилд иргэний нийгмийн оролцоог идэвхжүүлж, нийгмийн зөвшилцлийг хангана.
- *Жендэрийн тэгш байдлыг хангана:* Улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш оролцох, хяналт тавих, шийдвэр гаргах үйл ажиллагаанд шуударга ёсыг бэхжүүлнэ.

Г. Бүрэлдэхүүн хэсэг

Энэхүү бодлого нь дараахь бүрэлдэхүүн хэсэгтэй байна:

1. Хүн ам зүйн талаар:

- 1.1. Хүн амын төрөлт;
- 1.2. Хүн амын нас баралт;
- 1.3. Хүн амын байршил;
- 1.4. Дотоод шилжих хөдөлгөөн;
- 1.5. Гадаад шилжих хөдөлгөөн.

2. Хүн амын хөгжлийг хангах талаар:

- 2.1. Гэр бүл;
- 2.2. Жендэрийн тэгш байдлыг хангах;

- 2.3. Өсвөр үе, залуучууд;
- 2.4. Хүүхэд;
- 2.5. Ахмад настан, насжилт;
- 2.6. Тахир дутуу иргэд.

3. Хүний амьдралын чанарыг сайжруулах талаар:

- 3.1. Эрүүл мэнд;
- 3.2. Боловсрол;
- 3.3. Нийгмийн хамгаалал;
- 3.4. Орлого ба ядуурал;
- 3.5. Орон байр;
- 3.6. Хоол хүнс;
- 3.7. Байгаль орчин.

4. Бодлогыг хэрэгжүүлэх арга замын талаар:

- 4.1 Хүн амын бүртгэл, мэдээлэл, судалгаа;
- 4.2 Мэдээлэл, сурталчилгаа;
- 4.3 Чадавхийг бэхжүүлэх;
- 4.4 Түншлэл, хамтын ажиллагаа ба хөрөнгө нөөцийг дайчлах;
- 4.5 Хүн амын хөгжлийн талаарх үндэсний тогтолцоо;
- 4.6 Хяналт, шинжилгээ, үнэлгээ.

1. Хүн ам зүйн талаар

- Хүн амын бодлогын цөм - хүн ам зүйн талаар баримтлах чиглэлийн хүрээнд хүн амын тооны өөрчлөлтөд шууд нөлөөлөгч хүчин зүйл болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний асуудлыг цогцоор авч үзнэ.
- Хүний нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэсэн чөлөөт сонголт бүхий зохистой төрөлтийг дэмжиж өвчлөл, нас баралтыг бууруулах замаар хүн амын тогтвортой өсөлтийг хангана.
- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан зах зээлийн эрэлт хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцсэн хүн амын байршил дэмжиж дотоод шилжих хөдөлгөөний сөрөг үр дагаврыг арилган, гадаад шилжих хөдөлгөөний үр ашгийг нэмэгдүүлнэ.

1.1. Хүн амын төрөлт

- 1.1.1. Хүүхдийг оюун ухаан, бие бялдрын хувьд өв тэгш хөгжилтэй, эсэн мэнд, эрүүл чийрэг, сайн сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлж 20-39 насны эхчүүдийн 2-3 жилийн зайтай төрөлтийг түлхүү дэмжинэ.
- 1.1.2. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулж эхийн эндэгдэлд өртөмтгий бүлэг болон өсвөр, ахимаг насны эмэгтэйчүүдэд тэдний сонголтын дагуу жирэмслэлт, төрөлтөө зохицуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.1.3. Хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт, түүний хүндрэлийг бууруулах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- 1.1.4. Төрөхийн өмнөх, төрсний дараахь болон хүүхдээ өсгөхөд шаардлагатай эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, олгох тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 1.1.5. Гэр бүлийн хос 3 ба түүнээс дээш тооны хүүхэд төрүүлж, эсэн мэнд өсгөхийг урамшуулж, өрхийн орлогыг нь нэмэгдүүлэх чиглэл баримтална.
- 1.1.6. Хүн амын ялангуяа, эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх ойлголт, мэдлэг, үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, хүний эрх болон нөхөн үржихүйн эрхийг хангах орчныг бүрдүүлнэ.
- 1.1.7. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийг бэлгийн замын халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, эмчлэх, нөхөн сэргээх нийгэм, хамт олонд түшиглэсэн үйлчилгээг хөгжүүлнэ.
- 1.1.8. Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн ажлын байрыг хадгалж, хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж, улмаар түүний сарын цалингийн хэмжээнд хүргэнэ.

1.2. Хүн амын нас баралт

- 1.2.1. Эхийн эндэгдлийг 2015 он гэхэд 2000 оны түвшинээс 1/2-ээр, нялхасны эндэгдлийг 1/3-ээр тус тус бууруулна.
- 1.2.2. Хүн ам эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, буруу зуршлаас урьдчилан сэргийлэх, зан үйлийг өөрчлөх замаар хүн амын өвчлөл, нас баралт ялангуяа, нялхасны эндэгдэл, хүүхэд, залуучуудын цаг зуурын нас баралтыг бууруулан дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.
- 1.2.3. Вакцины хамралтыг нэмэгдүүлэх замаар хүн амын дархлаажуулалтыг сайжруулан, халдварт өвчнийг бууруулна.

1.3. Хүн амын байршил

- 1.3.1. Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасган байгаль орчны дээд, түүний нөөцтэй уялдуулан хүн амын зохисгүй бөөгнөрлийг сааруулж, дагуул хот, бүсийн тулгуур төвүүд болон булаг сууринг түшиглэсэн орон нутагтаа суурин амьдрах хүн амын байршлыг дэмжинэ.
- 1.3.2. Байгаль орчиндоо зохиссон бэлчээрийн болон фермерийн аж ахуй эрхэлж, нүүдлийн, хагас суурин хэвшлээр амьдарч буй хүн амд хүргэх орчин үеийн техникийн дэвшилд суурилсан зам, холбоо, эрчим хүч, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж, чанарыг тогтвортой сайжруулах бодлого баримтална.

1.4. Дотоод шилжих хөдөлгөөн

- 1.4.1. Бүсийн тулгуур төв, нийслэлийн дагуул хотыг хөгжүүлэх замаар хүн амын нүүдлийн болон суурин амьдралын зохистой харьцааг тогтоон, хүн ам хэт төвлөрсөн төв, суурин газарт чиглэсэн шилжих хөдөлгөөний эрчимжилтийг зохицуулна.
- 1.4.2. Хүн улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй шилжин суурьших эрхийг хүндэтгэж, ажиллах амьдрах газраа сонгох нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.4.3. Хүн амын орон нутагтаа тав тухтай амьдрал суурьших нөхцөлийг хангаж, байгаль орчны зохисгүй өөрчлөлт, зах зээлийн болзошгүй эрсдлээс хамгаална.
- 1.4.4. Шилжин суурьшигчдын нийгмийн үйлчилгээнд ногдох зардлыг оршин сууж байсан аймаг, сумын төсвөөс шинээр шилжин суурьшсан газарт шилжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.

1.5. Гадаад шилжих хөдөлгөөн

- 1.5.1. Үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн монгол иргэд хилийн чанадад амьдарч ажиллах, мэдлэг боловсрол эзэмших, өндөр хөгжилтэй орнуудын дэвшилтэт техник, технологийг эх орондоо нэвтрүүлэх санаачилгыг урамшуулж, иргэд харилцан сурч хөдөлмөр эрхлэх талаар хоёр ба олон талт идэвхтэй хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжинэ.
- 1.5.2. Гадаадад ажиллаж байгаа монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах талаар мөнгө, санхүү, татварын оновчтой бодлого хэрэгжүүлж, мөнгөн гуйвуулгын найдвартай үйлчилгээг хөгжүүлнэ.
- 1.5.3. Монголоос гадаадад гарч буй өндөр

мэргэжлийн боловсон хүчин, өндөр мэргэжил эзэмшсэн монгол иргэдийг эх орондоо буцаан ирүүлэх сонирхлыг бий болгож, ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

- 1.5.4. Иргэдийг гадаадад хууль бусаар гарган хохироох, орлого олох аливаа үйлдлээс хамгаална.
- 1.5.5. Албан ёсоор гадаадад ажиллах хүч гаргаж байгаа субъект нь зуучилсан иргэнийг тухайн улсад хэвийн нөхцөлд амьдарч ажиллах боломжийг бүрдүүлэх, түүний эр гэрт туслах талаар гаргасан санаачилгыг дэмжинэ.
- 1.5.6. Гадаад шилжих хөдөлгөөний үйл явцыг олон улсын харилцаанд ач холбогдол бүхий стратегитэй уялдуулан боловсронгуй болгоно.
- 1.5.7. Гадаадад сурч ажиллах сонирхолтой монгол иргэдийг шаардлагатай мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлэх үйлчилгээг дэмжин хөгжүүлнэ.

2. Гэр бүл, хүн амын бүлгийн хөгжлийг хангах талаар

- Хүн амын насны бүтцийн өөрчлөлтөөс үүдэн гарах тулгамдсан асуудлыг хүн амын бүлгийн нас, бие, сэтгэхүй, чадамжийн онцлогт хирсон, гэр бүл төвтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар хүний хөгжлийг хангах чиглэл баримтална.
- Хүн амын бүлэгт хүүхэд, өсвөр үе, залуучууд, эмэгтэйчүүд, тахир дутуу иргэд, ахмад настныг хамруулж, тэдний хөгжлийн асуудлыг хүний эрх, жөндөрийн тэгш байдлыг хангах төрийн бодлоготой уялдуулан цогцоор авч үзнэ.
- Хүнд нөхцөлд байгаа хүүхэд, ахмад настан, ядуу, нэн ядуу иргэд, тахир дутуугийн хоёр болон түүнээс дээш төрөлд хамрагддаг эмээг хэсгийн хүмүүс, шилжин суурьшигчид болон үндэстэн ястны онцлог асуудалд онцгой анхаарна.

2.1. Гэр бүл

- 2.1.1. Гэр бүл нь хүний амьдралын анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж гэж үзэж түүний хөгжлийн тухай асуудлыг төрийн бодлогын төвд байлгана.
- 2.1.2. Гэр бүлийн харилцаанд жөндөрийн тэгш байдлыг хангана.
- 2.1.3. Үндэсний өв соёл, удам угсаагаа хүндэтгэн ирсэн ёс заншлыг хүүхэд, залуучуудад уламжлуулан хөгжүүлэхийг дэмжин урамшуулна.
- 2.1.4. Өмчийн харилцаанд гэр бүлийн гишүүн бүрийг тэгш эрхтэйгээр оролцуулах, эдийн

засгийн талаар бие даан хөгжих, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.

- 2.1.5. Гэр бүлийн хөдөлмөрийн чадвартай гишүүдийн ачааллыг багасгах, тусгай асаргаа шаардлагатай бага насны хүүхэд, өндөр настан, тахир дутуу иргэдэд зориулсан нийгмийн үйлчилгээг бий болгон хөгжүүлнэ.
- 2.1.6. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах эрх зүй, зан үйл, хандлагын эерэг орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 2.1.7. Хүүхдийн эрх, хөгжил, хамгаалалд эцэг, эхийн тэгш оролцоог хангахад чиглэсэн гэр бүлд үзүүлэх дэмжлэгийн хүрээг өргөжүүлнэ.

2.2. Жендэрийн тэгш байдлыг хангах

- 2.2.1. Жендэрийн тэгш байдлыг эдийн засаг, нийгэм, улс төр, соёл, гэр бүлийн болон хүний эрхийн хүрээнд хангах, аливаа тэгш бус байдал, ялгаварлал, хавчин гадуурхлын бүх шалтгааныг багасган, улмаар арилгах чиглэл баримтална.
- 2.2.2. Эдийн засгийн өсөлтийг хангах, үр дүнг шударга хуваарилах, нийгмийн хөгжлийг дэмжсэн нийгмийн хамгааллын бодлогод жендэрийн асуудлыг тусган хэрэгжүүлнэ.
- 2.2.3. Улс төр, өмчийн харилцаа, удирдах болон шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн уламжлалт үүргийг өөрчлөх сэтгэлгээг хүн амын ухамсарт төлөвшүүлнэ.
- 2.2.4. Хөдөлмөрийн чадвар бүхий гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлт, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ядуурлаас хамгаалах, эрүүл мэндийн доройтлыг арилгах, гэрийн хөдөлмөрийн ачааллыг хөнгөвчлөхөд онцгой анхаарч, эмэгтэйчүүд өөрсдийн чадавхи, бололцоогоо бүрэн ашиглах явдлыг хөхиүлэн дэмжинэ.
- 2.2.5. Эмэгтэйчүүдийн орлогыг нэмэгдүүлэх, эдийн засгийн хувьд бие даах, хөдлөх, үл хөдлөх өмч эзэмших эрхийг бүрэн эдлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авна.
- 2.2.6. Эмэгтэйчүүд, хүүхдийг хэрцгийлэх, доромжлох, тарчилган зовоох зэрэг хүчирхийллийн бүх хэлбэр болон тэднийг худалдах, биеэ үнэлэхийг албадах, хөслөх (янхан болгох) зэрэг гаж буруу замд татан оруулахаас сэргийлнэ.
- 2.2.7. Ерөнхий боловсролын болон бүх шатны мэргэжлийн сургуульд эрэгтэйчүүдийн суралцах, боловсрол эзэмших таатай орчинг бүрдүүлж, 2005 он гэхэд бага, 2010 он гэхэд дунд, 2015 он гэхэд бүх шатны боловсрол дахь жендэрийн тэгш бус байдлыг арилгана.

2.3. Өсвөр үе, залуучууд

- 2.3.1. Өсвөр үе, залуучуудыг оюун ухаан, бие бялдрын өв тэгш хөгжилтэй, нийгмийн хөгжлийг бүтээх, хяналт тавих, боловсролгүй болгоход хувь нэмрээ оруулах, шийдвэр гаргахад санаа бодлоо илэрхийлж оролцох чадвартай, идэвхтэй иргэд болгон төлөвшүүлэхэд төрийн бодлого чиглэгдэнэ.
- 2.3.2. Залуу гэр бүлийг орон сууцаар хангах, орлогыг нь нэмэгдүүлэх, зээл, хөгжлийн тусламжид хамруулах боломжийг өргөжүүлнэ.
- 2.3.3. Өсвөр үе, залуучуудын албан ба албан бус боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэндийн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан байдлыг нь хангаж, бүтээлч чадварыг хөгжүүлнэ.
- 2.3.4. Залуучуудад байгаль орчин, эх хэл, бичиг үсэг, ёс заншил, соёл иргэншил, удам угсаагаа дээдлэх үзлийг төлөвшүүлэхэд анхаарна.
- 2.3.5. Өсвөр үе, залуучуудын амралт, чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлж, хөгжих таатай орчинг бий болгоно.
- 2.3.6. Залуучуудын хэрэгцээ, сонирхол, насанд нь тохирсон, эрхийг нь хангасан нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дэмжин хөгжүүлнэ.
- 2.3.7. Залуу гэр бүлийн хэрэгцээ, бололцоонд нь тохирсон хүүхэд асрах, халамжлах, хөгжүүлэх үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгоно.
- 2.3.8. Шинээр гэр бүл болсон залуучуудад бие даан амьдрахад нь төрөөс дэмжлэг үзүүлнэ.

2.4. Хүүхэд

- 2.4.1. Хүүхдийг дээдлэх зарчимд нийцүүлэн тэдний эрхийг хамгаалах, хөгжүүлэх, хүссэн боловсрол, мэргэжлээ эзэмших орчныг бүрдүүлэх, гэр бүлдээ эрүүл энх, сайн сайхан амьдрах таатай нөхцөлийг хангана.
- 2.4.2. Хүүхэд бүр халамж, анхаарал хүртэх, эсэн мэнд бойжих, хөхөөр хооллох нөхцөл боломжийг бүрдүүлнэ.
- 2.4.3. Сургуулийн өмнөх, бага, дунд боловсролыг хүүхэд бүрт эзэмшүүлэх таатай орчныг бүрдүүлж боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарын ялгааг арилгана.
- 2.4.4. Хүүхдийн сэтгэц, өсөлт, хөгжлийн онцлогт нийцсэн хоол хүнсээр хангаж эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, нөхөн сэргээх үйлчилгээг хөгжүүлнэ.

- 2.4.5. Тахир дутуу, эмгэг согогтой, хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг нийгэм, хамт олны дунд төлөвших таатай орчинг бүрдүүлнэ.
- 2.4.6. Хүүхдийг үл хайхрах, хаях, доромжлох, хүчирхийлэх, хэрцгийлэх, гэмт хэрэг, садар самууны зорилгоор ашиглах, татан оруулах, дамжуулан худалдах зэрэг болзошгүй аюулаас хамгаална.
- 2.4.7. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгана.
- 2.4.8. Хүнд нөхцөлд байгаа хүүхдэд зориулсан нийгмийн цогц үйлчилгээг бий болгоно. Гэр бүлд түшиглэсэн, хүүхдийн оролцоонд тулгуурласан халамж, асрамжийн үйлчилгээг төрөөс урамшуулан дэмжинэ.
- 2.4.9. Өнчин хүүхдийг гэр бүлийн нөхцөлд өсч хөгжих бололцоогоор хангасан үрчлэгч, асрамжлагч, халамжлагч гэр бүлийг урамшуулан дэмжинэ.
- 2.5. Ахмад настан, насжилт
- 2.5.1. Ахмад настан нийгмийн идэвхтэй гишүүн байж, хүсэл сонирхлынхоо дагуу утга төгөлдөр амьдрах орчныг бүрдүүлж, амьдралын чанарыг нь дээшлүүлнэ.
- 2.5.2. Ахмад настныг насны доройтлоос хамгаалахад чиглэсэн нөхөн сэргээх үйлчилгээг хөгжүүлж, эрүүл насжилтыг дэмжих бодлого баримтална.
- 2.5.3. Ахмад настанд үзүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, тогтмолжуулна.
- 2.5.4. Ахмад настанд насан туршийн боловсрол олгох, дахин сургах хөтөлбөрт хамруулж, тэдний бололцоо, сонирхол, хэрэгцээнд тохирсон хөдөлмөр эрхлэхийг дэмжин, эдийн засаг, нийгмийн амьдралд оролцох оролцоог нь нэмэгдүүлнэ.
- 2.5.5. Ахмад настны мэдлэг, ажлын дадлага туршлагыг хүүхэд залуучуудад өвлүүлэхийг хөхиүлэн дэмжинэ.
- 2.5.6. Ахмад настанд туслах, тэднийг идэвхтэй амьдрахад чиглэсэн нийгмийн үйлчилгээний нэр төрөл, чанар, хүртээмжийг цогцоор нь сайжруулахын хамт энэ чиглэлээр иргэний нийгэм, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын бүхий л санаачилгыг урамшуулан дэмжинэ.
- 2.6. Тахир дутуу иргэд
- 2.6.1. Тахир дутуу хүмүүсийн нөөц бололцооны талаарх шинэ хандлага, ойлголтыг бэхжүүлж, нийгмийн идэвхтэй гишүүд байлгах чиглэл баримтална.
- 2.6.2. Тахир дутуу хүмүүст зориулсан эмнэлгийн болон нийгмийн үйлчилгээ, нөхөн сэргээх эмчилгээний нэр төрөл, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.6.3. Тахир дутуу хүний хязгаарлагдмал боломжид тохирсон амьдрах орчны дэд бүтцийг сайжруулж, нийгмийн зүгээс тэдэнд хандах таатай хандлагыг төлөвшүүлнэ.
- 2.6.4. Тахир дутуу хүмүүс нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын амьдралд оролцох, нөхөн үржихүйн эрхээ эдлэх, гэр бүл болоход тулгарч болох гадуурхлын аливаа хэлбэрийг арилгах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.6.5. Тахир дутуу хүмүүст зориулсан нийгэм, хамт олонд түшиглэсэн үйлчилгээг хөгжүүлнэ.
- 3. Хүний амьдралын чанарыг сайжруулах талаар**
- Хүн ам эрүүл орчинд амьдрах, хөдөлмөрлөх, амьдрал ахуйгаа сайжруулах, мэдлэг боловсрол эзэмшин нийгмийн амьдралд үр бүтээлтэй оролцох, хөгжих орчныг нь бүрдүүлэх замаар хүний амьдралын чанарыг сайжруулах чиглэл баримтална.
- 3.1. Эрүүл мэнд
- 3.1.1. Хүн эрүүл байх эрхээ эдлэхэд шаардлагатай, хүрэлцээтэй, хүртээмжтэй, сэтгэлд нийцсэн, чанартай эрүүл мэндийн үйлчилгээг хүн амд хүргэж, олон улсын жишигт ойртуулна.
- 3.1.2. Эрүүл мэндийн үйлчилгээний байр, тоног төхөөрөмжийн хүртээмж, үйлчилгээний үнэ нь иргэдийн төлбөрийн чадвартай уялгдсан, иргэдэд тэгш үйлчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.1.3. Иргэд өөрийн эрүүл мэндийг хамгаалах асуудалтай холбоотой мэдээллийг хайх, олж авах тогтолцоог бүрдүүлнэ.
- 3.1.4. Эрүүл хоол хүнс, орон байр, ундны ус, шаардлага хангасан аюулгүй ажлын байр, хүрээлэн байгаа орчныг бүрдүүлж, хүн амьс эрүүл, эсэн мэнд амьдрах нөхцлөөр хангана.
- 3.1.5. Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, хорт зуршил, өвчин эмгэг, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зан үйлд сургах замаар өвчлөл эндэгдлийг бууруулна.
- 3.1.6. Хүний амьдралын чанарт сөргөөр нөлөөлж өвчин эмгэг, осол гэмтэлд хүргэж буй хүчин зүйлээс сэргийлэх, улмаар шалтгаан, үр дагаврыг арилгана.
- 3.1.7. Хүн амын эрүүл мэндийг байгалийн хүчин зүйлээр нөхөн сэргээх, рашаан усыг эмчилгээ сувилгаанд хэрэглэхийг хөхиүлэн дэмжинэ.

- 3.1.8. Гэр бүлд угийн бичгийг хөтлүүлж, цус ойртох, удамшлын өвчнөөс хүн амыг сэргийлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 3.2. Боловсрол
- 3.2.1. Хүн өөрөө хөгжлийн үйл явцын идэвхтэй гишүүн байж амьдралын дадал, чадвар эзэмших, эрх мэдэл, амьжиргааны түвшингээ дээшлүүлэх гол хэрэгсэл нь боловсрол гэж үзэж, боловсролын чанар, хүртээмж, үр ашиг, түүнээс авах сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.
- 3.2.2. Хүн бүрт боловсрол эзэмших тэгш сонголт, адил боломжийг олгож, хүүхдэд суурь боловсролыг заавал, насанд хүрэгчдэд хэрэгцээтэй боловсролоо өөртөө тохиромжтой хэлбэрээр, бололцоотой хугацаандаа тасралтгүй эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.2.3. Мэргэжлийн боловсрол олгох сургалтын агуулга, арга технологийг уян хатан болгож хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, хөрвөх чадвартай мэргэжилтэй боловсон хүчний бэлтгэнэ.
- 3.2.4. Насанд хүрэгчдийн бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгана.
- 3.2.5. Хүн амын оюуны бүтээлийн үнэлэмжийг эрс дээшлүүлэх эрх зүйн орчинг бий болгож, хэрэгжүүлнэ.
- 3.3. Нийгмийн хамгаалал
- 3.3.1. Нийгмийн хамгааллын үйлчилгээнд иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 3.3.2. Нийгмийн халамж, өсрэмжийн үйлчилгээний төвлөрлийг сааруулж, нийгэм, хамт олонд түшиглэсэн хэлбэрийг гэр бүлд чиглэсэн цогц үйлчилгээ болгон өргөжүүлж, нийгмийн ажлыг хөгжүүлнэ.
- 3.3.3. Эдийн засгийн идэвхтэй нийт хүн амыг тэтгэврийн даатгалд хамруулах, тэтгэврийн санг бүрдүүлэх олон хэлбэрийг бий болгож, нэг хүнд ногдох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 3.3.4. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний нэр төрөл, чанар, хүртээмжийг тасралтгүй сайжруулж, үйлчилгээг хэрэглэгчдэд ойртуулж, хөдөлмөрийн бүтээмж, үнэлэмжийн асуудалд анхаарна.
- 3.3.5. Хэрэглэгчдийг чанарын баталгаатай бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээгээр хангах, энэ талын мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- 3.4. Орлого ба ядуурал
- 3.4.1. Ядуурлыг бууруулах, ажилгүйдлийг багасгахад иргэдийг идэвхтэй оролцуулж, тэдэнд хөгжлийн тусламж, дэмжлэг үзүүлэх замаар нийгмийн эмзэг хэсгийн амьжиргааны баталгаажих түвшинд амьдрах эрхийг хангана.
- 3.4.2. Хүн амыг орлогын болон оюуны ядууралд өртөхөөс урьдчилан сэргийлнэ.
- 3.4.3. Хүн амын амьжиргааны чадвархийг дэмжин хөгжүүлэх эдийн засаг, нийгэм, дэд бүтцийн зайлшгүй үйлчилгээ, технологи, мэдээллийн хүртээмжийг өргөжүүлнэ.
- 3.4.4. Эмзэг, ядуу, дунд хэсгийн хүн амд насан туршдаа суралцах, нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүртэх, хөдөлмөр эрхлэх, эдийн засгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох боломжийг бүрдүүлэх замаар орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, удам дамжсан ядууралд өртөхөөс хамгаална.
- 3.4.5. Ядуу, нэн ядуу өрхийг орлогыг нь нэмэгдүүлэх хөгжлийн эзэл, тусламжид хамруулах замаар ядуурлаас гаргана.
- 3.4.6. Сургууль зэвсэрдалтыг багасгах, суралцах таатай орчныг бий болгох, мэргэжилтэй багшлах боловсон хүчний хангамжийг сайжруулах замаар хөдөө дэх оюуны ядуурлыг бууруулна.
- 3.4.7. Хүн амын амьжиргааны түвшинг тухайн үеийн инфляцийн түвшинтэй уялдуулан хүний амьдралын наад захын хэрэгцээг хангахуйц хүрэлцээтэй хэмжээгээр тогтооно.
- 3.5. Орон байр
- 3.5.1. Хүн амын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг нь сайжруулахад чиглэсэн эдийн засаг, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэл баримтална.
- 3.5.2. Хот сууринд амьдардаг хүн амын орон сууцны фондыг нэмэгдүүлж, нөхцөлийг нь сайжруулах, хөдөө орон нутагт нүүдэллэн амьдардаг хүн амыг уламжлалт гэр сууцаар хангахад дэмжлэг үзүүлнэ.
- 3.5.3. Иргэдийн хөдөлмөр, хөрөнгө хоршин орон сууц барих хөдөлгөөнийг хөхиүлэн дэмжинэ.
- 3.5.4. Залуу гэр бүл, оюутнуудад зориулсан орон сууцны цогцолбор, нийтийн байр барих, аж ахуйн нэгж, байгууллагаас ажиллагчдаа орон байраар хангах талаар гаргасан санал санаачилга, хөдөлгөөнийг хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжинэ.
- 3.6. Хоол хүнс
- 3.6.1. Хүн амын хоол хүнсний хангамжийг сайжруулж, калори, амин дэмээр баялаг экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах

чиглэл баримтална.

- 3.6.2. Монгол хүний хоол хүнсний физиологийн нормыг нас, хүйс, ажил мэргэжлийн онцлог, нутаг дэвсгэр, уур амьсгалын онцлогтой уялдуулан тогтооно.
- 3.6.3. Хүн амын хүнсний аюулгүй байдалд тавих эрүүл ахуй, халдвар судлалын хяналтыг тогтмолжуулна.
- 3.6.4. Бага насны хүүхэд, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, ахмад настан болон тусгай хоол хүнс хэрэглэдэг хүн амын хоол хүнсийг үйлдвэрлэх, хадгалах, түгээх үйлчилгээний сүлжээг хөгжүүлнэ.
- 3.6.5. Хоолыг орлох, дутагдалтай эрдэс бодисыг нөхөх нэмэгдэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааг дэмжинэ.
- 3.6.6. Хүн амыг зохистой зөв хооллох, эрүүл хүнс хэрэглэж хэвших, хорт зуршлаас өөрийгөө хамгаалахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлнэ.

3.7. Байгаль орчин

- 3.7.1. Байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, нөөц баялгийг зохистой ашиглах, байгаль экологид халгүй технологи, үйлдвэрлэл хөгжүүлэх замаар хүн байгальтайгаа зохицож өөрийн чадавхи, нөөцөд түшиглэн, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.7.2. Ган, зуд, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт зэрэг байгалийн гамшигийн улмаас хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрахад сөргөөр нөлөөлж болох хүчин зүйлийн нөлөөг багасгах талаар гаргасан санал санаачилгыг урамшуулан дэмжинэ.
- 3.7.3. Хүн амыг олноор хөнөөх аюултай өвчин тахал гарах, ой мод, бэлчээр, ургамлыг устгах хортон шавьж олшрох, агаар, ус, хөрсөөр дамжин цацраг идэвхт бодис, химийн бохирдол ихсэхээс сэргийлнэ.
- 3.7.4. Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж хот суурин газрын ногоон бүсийг бохирдлоос хамгаална.
- 3.7.5. Хүн амын хэт төвлөрлөөс үүдэн байгаль орчны тэнцвэр алдагдахаас урьдчилан сэргийлнэ.
- 3.7.6. Усны нөөцийг ашиглах, хамгаалах менежментийг сайжруулж нэг хүнд ноогдох эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усны хэрэглээг 2015 он гэхэд хоногт дунджаар 20 литр хүргэнэ.

4. Бодлогыг хэрэгжүүлэх арга замын

талаар

- Олон нийт, шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчдад мэдээлэл хүргэх, ухуулга сурталчилгаа явуулах, сургалт

судалгаа хийх үндэсний чадавхийг бэхжүүлэх замаар хүн амын хөгжлийн асуудлаарх дэмжлэгийн таатай орчныг бүрдүүлнэ.

- Хүн ам, хөгжлийн асуудалд улс төр, нийгэм, эдийн засгийн дэмжлэгийг бүх шатанд бүрдүүлэх, хөрөнгө нөөцийг дайчлах, харицан мэдээлэл солилцох, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, туршлага солилцох, ололт амжилтаа бататгах чиглэлээр түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

- Хүн амын асуудлыг үндэсний стратеги, бодлогыг тодорхойлох, хөтөлбөр, үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх, уялдуулан зохицуулах, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.

4.1. Хүн амын бүртгэл, мэдээлэл, судалгаа

- 4.1.1. Иргэний болон хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн сүлжээ бий болгож мэдээллийн бусад сантай холбон, хүн ам, хөгжлийн асуудлаарх мэдээллийн цогц сан байгуулна.
- 4.1.2. Бүртгэлийн нэгдсэн сүлжээг найдвартай ажиллуулахад шаардлагатай орчин үеийн техник хэрэгслээр хангана.
- 4.1.3. Хүн амын талаарх мэдээлэл, судалгааны чанарыг олон улсын түвшинд хүргэж бүртгэлд хамралтын түвшинг байнга нэмэгдүүлнэ.
- 4.1.4. Хүн амын хүчин зүйлийг хөгжлийн төлөвлөлтөд тусгахад шаардлагатай статистик мэдээлэл цуглуулж боловсруулах, хэрэгцээ, тулгамдсан асуудлын талаарх хэтийн тооцоо, судалгааны үр дүнг хэрэглэгчдэд шуурхай хүргэх тогтолцоог бүрдүүлнэ.
- 4.1.5. Хүйсээр ангилсан мэдээлэл, судалгааг өргөжүүлнэ.
- 4.1.6. Орчин үеийн судалгаа шинжилгээний арга зүй, ололтод үндэслэн монгол хүн судлалыг хөгжүүлнэ.

4.2. Мэдээлэл, сурталчилгаа

- 4.2.1. Хүн ам, хөгжлийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлахад мэдээллийн хэрэгслийн үр нөлөөг дээшлүүлнэ.
- 4.2.2. Тогтвортой хөгжлийн талаарх хүн амын ойлголтыг сайжруулах, эрхийг хангах, хөгжлийн үйл явцад тэдний гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлнэ.

- 4.2.3. Хэрэглэгчдийг мэдээ мэдээллээр цаг алдалгүй хангах, хүн амд хургах үйлчилгээг шуурхай болгоход чиглэсэн мэдээллийн шинэ технологийн хэрэглээ, хангамжийг нэмэгдүүлнэ.
- 4.2.4. Хүн ам, хөгжлийн асуудлаар дэмжлэгийн таатай орчинг бүрдүүлэхэд чиглэсэн ухуулга сурталчилгааг эрчимжүүлнэ.
- 4.2.5. Хүн амын мэдээлэл хүлээн авах орчныг сайжруулах, орон нутгийн хэвлэл мэдээллийн сүлжээг өргөтгөж үйлчилгээг нь хүртээмжтэй болгох, ялангуяа, алслагдсан нутгийн хүн амд мэдээлэл хүргэх, хүлээн авах, дамжуулах боломжийг сайжруулна.
- 4.3. Чадавхийг бэхжүүлэх
- 4.3.1. Хүн ам, хөгжлийн асуудлыг улс орны нийгэм, эдийн засгийн шинэ нөхцөл байдалд цогцоор авч үзэх, стратегийн төлөвлөлт, бодлого, хөтөлбөрт уялдуулан үндэсний чадавхийг бэхжүүлнэ.
- 4.3.2. Хүн ам судлал, хүн ам, хөгжлийн асуудлаар үндэсний түвшинд мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэхийг дэмжинэ.
- 4.3.3. Хүн ам, хөгжлийн сургалтын баазыг бэхжүүлэх, сургалтын бүтэц, агуулга, технологийг олон улсын жишигт хүргэж боловсронгуй болгоно.
- 4.4. Түншлэл, хамтын ажиллагаа ба хөрөнгө нөөцийг дайчлах
- 4.4.1. Хүн амын хүчин зүйлсийг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусган үндэсний бодлого, хөтөлбөрийн уялдаа холбоог сайжруулах, хэрэгжүүлэхэд төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааг идэвхжүүлнэ.
- 4.4.2. НҮБ, түүний төрөлжсөн байгууллага болон гадаад орнуудын дэмжлэгийг хүн ам, тогтвортой хөгжлийн талаарх үндэсний бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, олон улс, бүс, дэд бүсийн хэмжээнд хамтран ажиллах, хөрөнгө нөөцийг дайчлах таатай орчинг бүрдүүлэхэд чиглүүлнэ.
- 4.4.3. Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглалыг бүрдүүлэх, төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд өмчийн бүх хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн гаргасан санал санаачилга, хөрөнгө оруулалтыг урамшуулан дэмжиж хамтран ажиллана.
- 4.4.4. Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагын зүгээс хүн ам, хөгжлийн хүрээний асуудлыг тодорхойлох, хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог өргөжүүлэх чиглэлээр гаргаж буй санал, санаачилгыг дэмжинэ.
- 4.5. Хүн амын хөгжлийн талаарх үндэсний тогтолцоо
- 4.5.1. Монгол Улсын Их Хурал (Парламент) нь хүн амын хөгжлийн талаарх бодлогыг тодорхойлон эрх зүйн орчинг боловсронгуй болгож, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилт, энэ чиглэлээр Засгийн газраас явуулж буй үйл ажиллагаанд хяналт тавина.
- 4.5.2. Засгийн газар нь хүн ам ба хөгжлийн талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээ, энэхүү бодлогын биелэлтийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын нэгдсэн төсөвт тусган зохион байгуулах, хөрөнгө нөөцийг хуваарилах, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг арга зүйн удирдлагаар хангах, санал санаачилгыг урамшуулан дэмжих, уялдуулан зохицуулах ажлыг УИХ-ын өмнө шууд хариуцна. Хүн амын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд хүн амын хөгжлийн асуудлыг хэрэгжүүлэх үндэсний тогтаортой чадавхи бүхий бүтцийг бүрдүүлнэ.
- 4.5.3. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь хүн амын хөгжлийн асуудлыг орон нутгийн хөгжлийн төлөвлөлтөд тусган хэрэгжүүлдэг буй байдалд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, энэ үйл ажиллагаанд орон нутгаас зарцуулах хөрөнгө нөөцийг нэмэгдүүлэх, иргэдийн ашиг сонирхлыг хамгаалан шийдвэр гаргах үйл явцад тэдний идэвхтэй оролцоог хангана.
- 4.5.4. Хүн ам, хөгжлийн асуудлаарх зөвшилцлийн байгууллага нь энэхүү бодлогын хэрэгжилтийн байдалд хяналт тавих, зөвлөмж гаргах, цаг үеийн шинжтэй арга хэмжээг уялдуулан зохицуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулна.
- 4.5.5. Иргэний нийгэм хүний эрх, эрх чөлөө, хөгжил зэрэг аливаа асуудлаар гаргасан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ялгаварлал, шударга бус үйлдлийг таслан зогсооход идэвхтэй хамтран ажиллана.
- 4.6. Хяналт, шинжилгээ, үнэлгээ
- 4.6.1. Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас түншлэгч талуудтай хамтран Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд үе шат бүрийн эцэст хяналт, шинжилгээ, үнэлгээг хийнэ.
- 4.6.2. Хяналт, шинжилгээ, үнэлгээний үр дүн, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан энэхүү бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хүн ам, хөгжлийн талаарх тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авна.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

Дугаар 22

Улаанбаатар

2004 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

Зарим газар нутгийг улсын тусгай

хамгаалалтад авах тухай

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь заалт, Засгийн газрын саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Байгаль орчны тэнцэл, унаган төрхийг хадгалах шаардлага, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд ач холбогдолтойг харгалзан Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг дахь Шилийн богд уул, Хөргийн хөндий орчмын газар нутгийг дурсгалт газрын ангилалаар улсын тусгай хамгаалалтад авахаар тогтоосугай.

2. Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг дахь Ганга нуурын байгалийн дурсгалт газрыг мөн сумын нутаг дахь Алтан (дарь) овоо, Наран сумын нутаг дахь Молцог элс орчмын газар нутгаар

өргөтгөн Дарьгангын байгалийн цогцолборт газар болгон өөрчилж, хилийн заагийг хавсралтаар баталсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авахыг зөвшөөрөх тухай" Улсын Их Хурлын 1993 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 83 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн "Ганга нуур орчмын хэсэг газрыг Ганга нуурын дурсгалт газар" гэсэн 4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА**

Ж.БЯМБАДОРЖ

*Монгол Улсын Их Хурлын 2004 оны
22 дугаар тогтоолын хэвсрэлт*

ДАРЬГАНГЫН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГ

Баруун хойт захын цэг нь Сүхбаатар аймгийн Наран, Онгон сумын хилийн зааг дахь Тостын нуурын зүүн хойт эрэгт 45°17'29"-113°25'10" солбицолд орших 1 дүгээр цэг, түүнээс зүүн хойш 45°19'57"-113°29'53" солбицолд орших худаг, түүнээс зүүн урагш орших Хүнт (1152.6), Хүйтэн уул (1200.2), 45°16'15"-113°43'40" солбицолд орших Салаа булаг, түүнээс зүүн хойш 45°17'55"-113°47'45" солбицолд орших Шарменх, түүнээс баруун хойш эргэж 45°19'18"-113°45'40" солбицолд орших Хамар булаг, түүнээс зүүн тийш 45°19'00"-113°50'25" солбицолд орших 2 дугаар цэг, түүнээс урагш 45°18'30"-113°50'20" солбицолд орших 3 дугаар цэг, түүнээс баруун урагш 45°18'10"-113°49'40" солбицолд орших 4 дүгээр цэг, түүнээс зүүн урагш 45°17'42"-113°50'20" солбицолд орших

5 дугаар цэг, түүнээс зүүн хойш Ганга нуурын дурсгалт газрын хилийн зааг дахь 45°17'54"-113°52'07" солбицолд орших 6 дугаар цэг, түүнээс зүүн урагш 1286.6 тоот өндөрлөг, түүнээс зүүн зүгт 1335.4 тоот өндөрлөг, түүнээс зүүн хойш Гангын цагаан овоо (1530.2), түүнээс зүүн урагш Бадрах уул (1423.7), түүнээс зүүн урагш 1395.5 тоот цэг, түүнээс баруун хойш 1358.4 тоот цэг, түүнээс баруун хойш орших Их бургасны худаг (1328.0), түүнээс баруун урагш 1370.4 тоот цэг, түүнээс баруун урагш Сүмтийн хар толгой, түүнээс баруун урагш 1290.7 тоот цэг, түүнээс баруун хойш 1189.0 тоот цэг, Наран, Онгон сумын хилийн зааг дахь Тостын нуурын зүүн хойт эрэгт 45°17'29"-113°25'10" солбицолд орших 1 дүгээр цэг.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

Дугаар 23

Улаанбаатар

2004 оны 4 дүгээр сарын 30-ний өдөр

Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах тухай

Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж 2004

оны 8 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд ирүүлэхийг Засгийн газар (Н. Энхбаяр)-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 5.5